



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 19 / 11
сарын 11 едөр

Дугаар ЗГ-1/170

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Байгалийн ургамалын тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



0003956



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар X97/
3051

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0014189

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

“ІҮ.ХЭЛЭЛЦСЭН нь:

Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.10.04 № 6/6692

таний 2019.09.23 ны № 01/6579-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт зааснаар Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Ч.ХҮРЭЛБААТАР

• 762224




МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс (976 51) 26 75 33, E-mail foregn@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2019. 10 04 № 1-1/4414
танай 2019. 09 28 бы № 04/6579-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) болон дагалдан гарах бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



15.10.2019
15.10.2019



БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол улсад газар, түүний хэвлүй, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна" гэж, гучин наймдугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт "Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах" гэж тус тус заасан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.8.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулахаар тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрөөс экологийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн 3.9.4-т "Ургамлын нөөц, тархац, амьтны тоо, байршил, агууллын нөөцийг нь судалж экологи-эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр аж ахуйн ач холбогдол, ашиглалтын хэлбэр, зохион байгуулалтыг нь бүсчлэн тогтоож, элбэг ургамал, амьтныг байгалийн хэвийн өсөлт, үргилтийг нь алдагдуулалгүй зохистой ашиглах, ургамал, амьтны гаралтай үнэт түүхий эд, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд өрсөлдөнө." гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.3.1-д "Ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөц баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй цогц байдлаар шийднэ." гэж тус тус тусгасан.

Манай орны ургамлын аймаг, түүний олон янз байдал нь Төв Ази, Сибирь, Алтайн уулс, Дорнод Азийн бүс нутгийн флорын төлөөлөгчдөөс бурдсэн өвөрмөц онцлогтой хэдий ч унаган ба завсрын унаган ургамал цөөнгүй, олон янз байдлын хувьд ядмаг, төрөл зүйл багатай тул цаашид бодлогын түвшинд тууштай хамгаалах нь чухал байна.

Байгалийн ургамлын ховордлын шалтгааны 59,3% нь хүний нөлөөгөөр, 38,6% нь нөөцийн хэт ашиглалтаас, 47,3% нь байгалийн гамшгаас үүдэлтэй байна.⁷

Тиймээс хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах асуудлыг хуулиар зохицуулах хэрэгцээ үүсч байна. Байгалийн ургамлын тухай хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийсэн судалгааны дагуу уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шаардлагатай байна.

Иймд дээрх хууль зүйн практик шаардлагыг үндэслэн Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 4 бүлэг 23 зүйлтэй байна.

Хуулийн төслийн 1 дүгээр бүлэгт хуульд тодорхойлох шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтыг дэлгэрэнгүй боловсруулж тусгана. Ургамал хамгаалал болон түүнтэй холбоотой харилцаанд баримтлах зарчим, иргэн хуулийн этгээд, ургамлын сан, түүний ангилал, үйл ажиллагааны удирдлагын ажиллах журмыг тогтооно.

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, ургамлын тархац, нөөц тогтоох судалгаа хийх нөхцөл болон үйл ажиллагааны хориглолттой журмыг тогтооно.

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт байгалийн ургамлыг зохистой ашиглах болон байгалийн ургамлыг тарималжуулах Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг нарийвчлан тусгана. Манай орон ургамлын зүйлийн бүрдлийн хувьд харьцангуй баялаг ч үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах нөөцгүй. Иймд ургамлын генетик нөөцийг нэмэгдүүлэх, удмын санг хамгаалах, эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой байгалийн ургамлыг тарималжуулах зүйл заалтыг нэмэлтээр оруулна. Байгалийн ургамал түүж бэлтгэх сонирхол бүхий иргэн, хуулийн эдгээдийн эрх, хүлээх үүргийг тодорхой зааж, ургамал түүх хугацаа, төлбөр, хураамжийн эрх зүйн үндсийг тогтооно.

⁷ Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид), Ц. Жамсрэн, Ч. Санчир, С. Бахман, Н. Сонинхишиг, С. Гомбобаатар, Ж. Е. М. Байллие, Ц. Цэндээхүү (редакторууд) (2012). Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль

Өнөөдөр, Монгол орны ургамлын аймаг, түүний олон янз байдалд гуурст (оим, нүцгэн болон далд үртэн) болон гуурсгүй (хөвд, замаг, мөөг, хаг) гэх ургамлын үндсэн 2 бүлэг багтдаг бөгөөд олон жилийн судалгааны үр дүнд Монгол оронд одоогоор 388 овогт хамаарах 1523 төрөлд багтах 7350 зүйл, дэд зүйл бүртгэгдэв¹. Үүнд 56 овгийн 156 төрлийн 574 зүйл, дэд зүйл дээд мөөг; 87 овгийн 268 төрлийн 2003 зүйл, дэд зүйл замаг; 63 овгийн 207 төрлийн 1033 зүйл, дэд зүйл хаг; 74 овгийн 208 төрлийн 580 зүйл, дэд зүйл хөвд; 108 овгийн 684 төрлийн 3160 зүйл, дэд зүйл гуурст ургамал тархсан байна². 3160 зүйл гуурст дээд ургамлаас унаган ургамал 153 зүйл (4.89%), завсрын унаган 458 зүйл (14.64%), нэн ховор 133 зүйл (4.25%), ховор 356 зүйл (11.38%), үлдэц (үлдвэр) ургамал 70 зүйл (0.99%) ургаж байна³.

Монгол орны ургамлын аймгийн зонхилох судалгааны дүнгээс тодорхой шалгуураар 3160 зүйл гуурст дээд ургамлаас үнэлгээ хийхэд 1472 зүйл /Нэн ховор 128 зүйл, ховор 355 зүйл, унаган 120 зүйл, завсрьн унаган 535 зүйл, Монгол орны Улаан дансанд бүртгэлтэй 148 зүйл, Монгол Улсын Улаан номонд орсон 134 зүйл, CITES-ийн жагсаалтад орсон 8 зүйл, усны 186 зүйл, уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий 484 зүйл, өндөр уулын 418 зүйл, Монгол орны зөвхөн нэг бүс нутагт тархсан 618 зүйл, үлдэц 70 зүйл нь, олон талын ач хобогдолтой 54 зүйл/ ургамал буюу нийт ургамлын 46%-ийг зайлшгүй хамгаалалтад авах шаардлага үүсээд байна⁴.

Монгол орны газар нутаг өргөн уудам, байгалийн бүс бүслүүр, ургах орчин олон янз боловч эрс тэс уур амьсгалтай, далайн түвшнээс харьцангуй өндөрт дэлхийн ургамал газарзүйн 4-н том бүс нутгийн заагт байрладаг. Цаашилбал уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, ган гачиг, уул уурхай зэрэг хүчин зүйлүүдээс гадна байгалийн ашигт ургамлын ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээ нэмэгдэж, хувь хүн, аж ахуйн нэгж ашиг орлого олох зорилгоор шинжлэх ухааны үндэслэлгүйгээр нэн ховор, ховор, элбэг ургамлыг байгалиас их хэмжээгээр түүж бэлтгэх болсонтой холбоотой олон зүйл ургамлын тархац хумигдах, илт ховордох, олон жил ургалгүй өнжих, зөв зохистой ашиглаагүйн улмаас цөөнгүй төрөл, зүйл ургамлын нөөц эрс багасаж, устах аюул нүүрлээд байна.

Өнөөдөр монгол орны бэлчээр нутгийн 70 гаруй хувь нь аль нэг байдлаар доройтсон нь эрдэмтдийн судалгаагаар нэгэнт тодорхой болсон⁵. Мал бэлчээрлэлт нь ургамлын үрийн нөхөн сэргэлтэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлж, ургамлын бүлгэмдлийн бүрэлдэхүүн, бүтцэд ихээхэн өөрчлөлт оруулж ургамлын баялаг хомсдох бас нэг шалтгаан болдог. Зөвхөн Дорнод аймгийн жишээн дээр авч үзвэл аймгийн нийт нутгийн 34,5% нь дунд, 26,5% нь их доройтсон байна⁶.

¹ Urgamal et al. 2016; Ургамал 2017

² Urgamal et al. 2016; Ургамал 2017; Urgamal 2018

³ Urgamal et al. 2016

⁴ Species catalogue of rare and threatened vascular plants of Mongolia M.Urgamal, 2018

⁵ Монгол орны байгаль орчин IV боть

⁶ Монгол орны байгаль орчин III боть

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт Монгол оронд ургадаг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис бүхий ургамалтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын нэгдэн орсон гэрээ, конвенци болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуультай уялдуулна. Мөн тус хуулийн зохицуулалтад хамарагдах иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хориглох зүйл, хариуцлагын хэлбэр, маргаан шийдвэрлэх талаар өнөөгийн хэрэгжиж буй хууль эрх зүйн орчинд тохируулан тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн дараахь үр дүн гарна. Үүнд:

1. Монгол орны нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтий ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр хангагдана;
2. 1995 онд батлагдсан нэн ховор ургамлын жагсаалт шинэчлэгдэнэ;
3. 1995 батлагдаж 2004, 2015 онд 2 удаа нэмэлт орсон ховор ургамлын жагсаалт шинэчлэгдэнэ;
4. Байгалийн ургамалд шинжлэх ухааны үндэслэлтэй экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоож, ургамал хамгааллын зөв хөшүүрэг бий болгох нөхцөл бүрдэнэ;
5. Байгалийн ургамлын удмын санг хамгаалж хойч үедээ өвлүүлэх нөхцөл бүрдэнэ;
6. Байгалийн ургамлыг тарималжуулах генетик нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөл бүрдэнэ;
7. Байгалийн ургамлын нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдал хадгалагдах нөхцөл бүрдэнэ;
8. Байгалийн ургамлын эсрэг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох эрх зүйн орчинд дэвшил гарч одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудтай нийцнэ;
9. Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилна;
10. Олон зүйл ургамлын нөөц болон тархацын мэдээлэлд өөрчлөлт орж, зөв зохистой ашиглах нөхцөл бүрдсэнээр улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ургамал ашиглахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн хэргийн гаралт багасах ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулттай нийцэх бөгөөд Байгалийн ургамлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.

----ооо----

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж 2018 онд батлуулна гэж тус тус заасан.

Манай орны ургамлын аймаг, түүний олон янз байдал нь Төв Ази, Сибирь, Алтайн уулс, Дорнод Азийн бүс нутгийн флорын төлөөлөгчдөөс бүрдсэн, байгалийн бүс бүслүүр, ургах орчин олон янз боловч эрс тэс уур амьсгалтай, далайн түвшнээс харьцангуй өндөрт байрладаг зэрэг онцлогтой, унаган, завсрын унаган ургамал цөөнгүй, олон янз байдал, төрөл зүйлийн тооны хувьд цөөн тул цаашид бодлогын түвшинд тууштай хамгаалах нь нэн чухал юм.

Өдгөө Монгол орны ургамлын аймагт 108 овгийн 684 төрлийн 3160 зүйл гуурст дээд ургамал бүртгэгдсэнээс унаган ургамал 153, завсрын унаган 458, нэн ховор 133, ховор 356 зүйл, үлдэц (үлдвэр) ургамал 70 зүйл ургамал бүртгэгдээд байна.¹

3160 зүйл гуурст дээд ургамалд тодорхой шалгуураар үнэлгээ хийхэд 1472 зүйл ургамал буюу нийт ургамлын 46%-ийг зайлшгүй хамгаалалтад авах шаардлага үүсээд байна.² Мөн Монгол орны бэлчээр нутгийн 70 гаруй хувь нь аль нэг байдлаар доройтсон нь³ мал бэлчээрлэлт ургамлын үрийн нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлж, ургамлын бүлгэмдлийн бүрэлдэхүүн, бүтцэд ихээхэн өөрчлөлт оруулж ургамлын баялаг хомсдох нэг шалтгаан болж байна. Байгалийн ургамлын ховордлын шалтгааны 59,3% нь хүний нөлөөгөөр, 38,6% нь нөөцийн хэт ашиглалтаас, 47,3% нь байгалийн гамшгаас үүдэлтэй байна.⁴

Байгалийн ургамлын тухай хуульд шинэчилсэн найруулга хийх зайлшгүй шаардлага үүсээд байгааг дараах баримтууд нотолж байна. Үүнд:

1. Байгалийн ургамлын тухай хууль 4 бүлэг 22 зүйлтэйгээр 1995 оны 06 сарын 05-ны өдөр батлагдаж, 1997-2015 онуудад 4 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон ч байгалийн ургамлын удмын санг хойш үедээ хадгалж өвлүүлэх чадамж дэлхий нийтийн жишгээс хоцорч, ургамлын олон янз байдлыг хамгаалах явдал үндсэндээ хаягдаж ургамлын

¹ Urgamal et al.2016

² Species catalogue of rare and threatened vascular plants of Mongolia M.Urgamal, 2018

³ Монгол орны байгаль орчин IV боть

⁴ Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид), Ц. Жамсран, Ч. Санчир, С. Бахман, Н. Сонинхишиг, С. Гомбобаатар, Ж.Е.М. Баиллие, Ц. Цэндээхүү (редакторууд) (2012). Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөөлөгчөөний эмхэтгэл. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль

төрөл зүйлүүд устах аюул тулгараад байгаа нь дээрх тоо баримт болон гадаад дотоодын эрдэмтэн судлаачид нотолж байна.

2. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийсэн үнэлгээнээс уг хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

Эдгээр шаардлагыг үндэслэн Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа:

1. Олон улсын гэрээ конвенцод заасан холбогдох үүргийг биелүүлэх нөхцөлийг бурдүүлж нутаг орны хэмжээнд нөөц багассан, устах аюулд өртөөд байгаа ургамлын зүйлийг уугуул тархац нутаг /in-situ/-т нь хамгаалах, нөхөн сэргээх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутагтаа хэрэгжүүлэх;

2. Нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын удмын санг хойч үедээ өвлүүлэх зорилгоор ижил төстэй /ex-situ/ орчинд тарималжуулан хадгалан хамгаалах ажлыг Төрийн өмчит шинжлэх ухааны байгууллага хийж гүйцэтгэх;

3. Монгол орны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн нийт ургамлын хатаамал, өсгөвөр, үр үрцэрийн цуглуулгыг байгалийн ургамлын генийн санд хадгалан хамгаалах;

4. Экосистемийн унаган төрхийг хадгалан хамгаалах зорилгоор харь зүйл ургамлыг байгальд тарьж ургуулахыг, хүнс техникийн зориулалтаар тарималжуулсан харь зүйл ургамлыг байгальд тархаахыг хориглох;

5. Харь зүйл ургамал тархахаас сэргийлэх, хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга орон нутгийн төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшин үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх;

6. Харь зүйл ургамал тархахаас сэргийлэх, хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга орон нутгийн төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшин үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх;

7. Байгалийн ургамлын биологийн нөхөн сэргээлт хийх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр биологийн нөхөн сэргээлт хийх, нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл дахин олгохгүй байх;

8.Нэн ховор, ховор, элбэг ургамлыг судалгаа шинжилгээний, ахуйн, зориулалтаар түүж бэлтгэх хэмжээг тодорхой болгосон;

9.Зөвхөн элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах;

10.Байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор байгалийн ургамлыг тарималжуулан ашиглах;

11.Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт, ашиглах, хэрэглэх, улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг Монгол улсын нэгдэн орсон конвенци болон "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуультай уялдуулах зэрэг зохицуулалтыг шинээр оруулж, холбогдох зүйл заалтыг өөрчлөн найруулсан.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулж, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 4 удаа хэлэлцүүлгийг зохион байгуулж, БОАЖЯ-ны вэб сайтад нээлттэй санал авахаар байршуулж саналыг тусгасан болно.

-оOo-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....-ний өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь байгалийн ургамал, түүний олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж

2.1.Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“байгалийн ургамал” гэж байгаль дээр өөрийн түүхэн хөгжлийн зүй тогтлын дагуу ургаж байгаа дээд болон доод ургамлыг;

3.1.2.”дээд ургамал” гэж тодорхой үүрэг бүхий үндэс, иш, навч, цэцэг, үржимс зэрэг эд эрхтэнтэй ургамлыг;

3.1.3.”доод ургамал” гэж тодорхой үүрэг бүхий эрхтэн ялгарч хөгжөөгүй, эгэл биетэй ургамлыг;

3.1.4.”байгалийн ургамлын түүхий эд” гэж судалгаа шинжилгээний, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тодорхой зүйл ургамлын газрын дээрх болон доорх хэсгийг;

3.1.5."газрын дээрх хэсэг" гэж хөрсний гадаргуугаас дээш байрлах иш, навч, цэцэг, үржимс, зэрэг эд эртнийг;

3.1.6 "газрын доорх хэсэг" гэж хөрсний гадаргуугаас доош байрлах үндэс, үндэслэг иш, булцуу зэрэг эд эрхтнийг;

3.1.7."унаган ургамал" гэж хязгаарлагдмал тархацтай зөвхөн Монгол орны нутаг дэвсгэрт тархан ургадаг дээд болон доод ургамлыг;

3.1.8."үлдвэр ургамал" гэж эртний гарал үүсэлтэй, өдгөө үлдэж хоцорсон ургамлыг;

3.1.9."биологийн нөөц" гэж тухайн зүйл ургамлын нийт тархац нутагтаа үүсгэж буй нөөцийн хэмжээг;

3.1.10."ашиглалтын нөөц" гэж тухайн газар нутгийн хувьд ашиглах ургамлын түүхий эдийн биологийн нөөцийн 20 хүртэлх хувийг;

3.1.11."байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа" гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг;

3.1.12."тарималжуулсан байгалийн ургамал" гэж байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор зориудаар тарьж ургуулсан байгалийн ургамал, тэдгээрийн үр, суулгацыг;

3.1.13."ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ" гэж батлагдсан аргачлалын дагуу тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдоор нь үнэлсэн нэгж жингийн мөнгөн үнэлгээг;

3.1.14."байгалийн ургамлын генийн сан" гэж Монгол улсын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн байгалийн дээд болон доод ургамлын бүх зүйлийн баримтжуулсан биет материалын хатаадас /гербари/, өсгөвөр, үр, үрцэрийн цуглуулгаас бүрдсэн сан хөмрөгийг;

3.1.15."харь зүйл ургамал" гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар тархан ургаж байгаа зүйл ургамлыг;

3.1.16."зөвшөөрөл" гэж байгалийн ургамлыг түүж бэлтгэх, гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулахад хуулийн этгээдэд төрийн захиргааны байгууллагаас олгох албан ёсны баримт бичгийг;

3.1.17."байгалийн ургамлын хамтын менежментийн нөхөрлөл" гэж нутгийн иргэдэд байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн дагуу байгуулсан нөхөрлөлийг;

4 дүгээр зүйл. Байгалийн ургамлын сан, түүний ангилаал

4.1. Байгалийн ургамлын сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ургаж байгаа дээд болон доод ургамлаас бүрдэнэ.

4.2.Байгалийн ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан дараах байдлаар ангилана:

4.1.1/нэн ховор;

4.1.2/ховор;

4.1.3/элбэг.

4.3.Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устаж байгаа болон устаж болзошгүй ургамал хамаарна.

4.4.Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай эмзэг ургамал хамаарна. Нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.

4.5.Энэ зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь хэсэгт зааснаас бусад ургамлыг элбэг ургамалд тооцно.

5 дугаар зүйл. Байгалийн ургамлын мэдээллийн сан

5.1.Байгалийн ургамлын мэдээллийн сан дараах хэсгээс бүрдэнэ:

5.1.1.байгалийн ургамлын олон янз байдлын тархац, нөөцийн хэмжээ, экологи-эдийн засгийн үнэлгээ;

5.1.2.ургамлын судалгааны, тайлан мэдээ;

5.1.3.байгалийн ургамлын биет цуглуулгын мэдээ;

5.1.4.байгалийн ургамлыг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ.

5.2.Байгалийн ургамлын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЙГАЛИЙН УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

6 дугаар зүйл. Байгалийн ургамлыг хамгаалах

6.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчны чиглэлээр төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн нутаг орны хэмжээнд нөөц багассан, устах аюулд өртөөд байгаа ургамлын зүйлийг угуул тархац нутагт нь хамгаалах, нөхөн сэргээх дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.

6.2.Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, харь зүйл ургамал тархахаас сэргийлэх ажлыг бүх шатны Засаг дарга орон нутгийн төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

6.3.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, хими, биологийн бодисын хортой нөлөөнөөс хамгаалах, хорио цээр тогтоох журмыг хуулиар тогтооно.

6.4.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно.

6.5.Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэхийг хориглоно.

6.6.Нэн ховор, ховор, унаган, болон үлдвэр ургамлын удмын санг хадгалан хамгаалах зорилгоор тарьж ургуулсан ургамлын цуглуулгыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагад хадгална.

6.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн байгалийн дээд болон доод ургамлын баримтжуулсан биет материалын хатаамал /гербари/, өсгөвөр, үр, үрцэрийн цуглуулгыг байгалийн ургамлын генийн санд хадгална.

6.8.Байгалийн ургамлын генийн сангийн үйл ажиллагааг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллага хариуцна. Байгалийн ургамлын генийн сангийн ажиллах журмыг байгаль орчны болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

6.9.Харь зүйл ургамлыг байгальд тарьж ургуулах, доройтсон газрыг нөхөн сэргээхийг хориглоно.

6.10.Иргэн, хуулийн этгээд хүнс, техникийн зориулалтаар тарьж байгаа харь зүйл ургамлыг байгальд тархаахыг хориглоно.

6.11.Доройтсон бэлчээрийг сайжруулдаа тухайн газар нутгийн бүлгэмдлийн үндсэн ургамлыг тарьж ургуулах бөгөөд энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан журмыг баримтлан гүйцэтгэнэ.

7 дугаар зүйл. Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох

7.1.Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

7.2.Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ хийх зардлыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3.Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.4.Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр тогтооно.

7.5.Байгалийн ургамлын тархац нөөцийн судалгааны тайланг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээллийн санд бүртгүүлнэ.

8 дугаар зүйл. Ургамлыг нөхөн сэргээх

8.1.Байгалийн ургамлын биологийн нөхөн сэргээлт хийх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.2.Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан хуулийн этгээд ургамлын биологийн нөхөн сэргээлт хийх журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийж тухайн шатны Засаг даргад хүлээлгэн өгнө.

8.3.Ургамал түүж бэлтгэсэн газартаа биологийн нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн дараа жилийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл олгохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БАЙГАЛИЙН УРГАМЛЫГ АШИГЛАХ

9 дүгээр зүйл. Байгалийн ургамлыг ашиглах зориулалт

9.1.Иргэн, хуулийн этгээд нэн ховор ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар, ховор ургамлыг судалгаа шинжилгээний болон ахуйн зориулалтаар, элбэг ургамлыг судалгаа шинжилгээний, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно.

10 дугаар зүйл. Байгалийн ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах

10.1.Хуулийн этгээдэд нэн ховор ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар түүх зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

10.2.Судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрийн түүхий эд болгон ашиглах, худалдан борлуулахыг хориглоно.

10.3.Судалгаа шинжилгээний зориулалтаар олгох нэг удаагийн зөвшөөрлийн хэмжээ нэн ховор ургамал тухайн үеийн жингийн газрын дээрх хэсэг 0,2 кг, газрын доорх хэсэг 0,2 кг, ховор ургамлын газрын дээрх хэсэг 0,5 кг, газрын доорх хэсэг 0,5 кг, элбэг ургамлын газрын дээрх хэсэг 1.5 кг, газрын доорх хэсэг 1,5 кг-аас илүүгүй байна.

11 дүгээр зүйл.Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах

11.1.Иргэн ховор ургамлыг гэр бүлийн хэрэгцээнд сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

11.2.Ахуйн зориулалтаар авсан зөвшөөрлийг бусдад дамжуулах, түүж бэлтгэсэн ховор ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, худалдан борлуулахыг хориглоно.

11.3.Ахуйн зориулалтаар нэг удаагийн зөвшөөрлөөр олгох ховор ургамал тухайн үеийн жингийн газрын дээрх хэсэг 3 кг, газрын доорх хэсэг 3 кг, элбэг ургамал газрын дээрх хэсэг 8 кг, газрын доорх хэсэг 8 кг-аас илүүгүй байна.

12 дугаар зүйл.Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

12.1.Байгалийн ургамлын мэргэжлийн байгууллагын эрх бүхий хуулийн этгээд элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар, ховор ургамлын ашиглалтын нөөцийн 10 хүртэлх хувийг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрлийн үндсэн дээр ашиглаж болно.

12.2.Тарималжуулсан байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болно.

12.3.Элбэг ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны биологийн нөөцийн 30 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тохиолдолд тухайн ургамлыг тарималжуулсан байна.

12.4.Байгалийн ургамлыг тарималжуулах, гадаад улсад гаргах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газар

13.1.Байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий дараах газар нутагт ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно:

13.1.1.хот, тосгон, бусад суурины ногоон бүс;

13.1.2.гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторхи газар;

13.1.3.нэн ховор амьтны байршил газар;

13.1.4.баянбүрд;

13.1.5. ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар;

13.1.6.элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар;

13.1.7.хөрсний элэгдлээс хамгаалах зурvas газар.

13.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 13.1 дэх хэсгийн 13.1.3, 13.1.4, 13.1.6, 13.1.7-д заасан газар, түүний заагийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

13.3. Энэ зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.4-т зааснаас бусад газарт мал аж ахуй, эрхлэх, мал бэлчээхийг хориглоно.

14 дүгээр зүйл. Байгалийн ургамлыг хадлан, бэлчээрийн зориулалтаар ашиглах

14.1.Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг иргэн, хуулийн этгээд оршин суугаа /оршин байгаа/ сум, дүүргийн газар нутагт мал бэлчээх, хадлан авах зэргээр бэлчээр, хадлангийн газар дахь ургамлыг ашиглахдаа Газрын тухай хуулийн 52, 53 дугаар зүйлийг баримтална.

14.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэн ховор ургамлыг хамгаалах зорилгоор түүний ургадаг газар мал бэлчээх, хадлан авахыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн 3 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно.

14.3.Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарийн дагуу, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

14.4.Байгалийн ургамлыг хадлангийн зориулалтаар бэлтгэн гадаад улсад гаргахыг хориглоно.

15 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох

15.1.Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг энэ хуулийн 7.4 дэх хэсэг болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

15.2.Ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг энэ хуулийн 7.4 дэх хэсэг болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

15.3.Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох байгууллага хүсэлт хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор шийдвэрлэнэ. Зөвшөөрлийг 30 хоногийн хугацаатай олгож, 30 хоногоор нэг удаа сунгана. Зөвшөөрлийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

15.5.Энэ хуулийн 15.4 дэх зүйлд заасан зөвшөөрлийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.6.Зөвшөөрөлд ургамал түүж бэлтгэх иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн нэр, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заана.

15.7.Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах зөвшөөрлийг үндэслэн ургамал түүж бэлтгэх газрыг иргэн, хуулийн этгээдэд зааж өгнө.

16 дугаар зүйл.Ургамлыг түүж бэлтгэх, гадаад улсад гаргах

16.1.Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд ургамал түүж бэлтгэх журам, стандарт, зөвшөөрлийг баримтлан түүнэ.

16.2.Байгалийн ургамал, түүний түүхий эдийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд хүсэлт хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор шийдвэрлэнэ. Зөвшөөрлийг 30 хоногийн хугацаатай олгож, 30 хоногоор нэг удаа сунгана.

16.3.Гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн ургамлыг аливаа зориулалтаар түүж бэлтгэхийг хориглоно.

16.4.Нэн ховор, ховор ургамал, түүний түүхий эдийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар гадаад улсад гаргахыг хориглоно.

16.5.Байгалийн ургамал түүж бэлтгэх, гадаад улсад гаргах, оруулахтай холбоотой журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17 дугаар зүйл. Байгалийн ургамлын хамтын менежментийн нөхөрлөл байгуулах

17.1.Нутгийн иргэд байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилгоор нөхөрлөл байгуулж хамтаар ашиглаж болно.

17.2.Нөхөрлөлийн үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ, төлөвлөгөө зэрэг зохион байгуулалтын үндсийг Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай хууль болон Иргэний хуулиар тус тус зохицуулна.

18 дугаар зүйл. Ургамал ашиглагчийн үүрэг

18.1.Ургамал ашиглагч нь дараах үүрэгтэй байна:

18.1.1.байгалийн ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх;

18.1.2.ургамал түүж бэлтгэх, нөхөн сэргээх журмыг баримтлах;

18.1.3.журам, зөвшөөрөлд заасан хэмжээ, хугацаанд ургамлыг түүж бэлтгэх;

18.1.4.ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх;

19 дүгээр зүйл. Ургамал ашигласны төлбөр

19.1.Иргэн, хуулийн этгээд төрийн өмчийн газар дээрх байгалийн ургамал ашигласны төлбөр төлнө.

19.2.Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөлийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

20 дугаар зүйл. Мансууруулах бодис бүхий ургамал

20.1.Мансууруулах бодис агуулсан ургамал гэж Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр конвенциор тодорхойлогдож, тэдгээрийн жагсаалтад орсон ургамлыг хэлнэ. Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

20.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис агуулсан ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад шинжлэх ухааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгож тэдгээрийг тусгай бүртгэлд бүртгэнэ.

20.3.Энэ хуулийн 20.2 дахь хэсэгт зааснаас бусад хуулийн этгээд мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарих, худалдан борлуулахыг хориглоно.

20.4.Мансууруулах бодис бүхий ургамлыг ашиглах, хэрэглэх, улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой асуудлыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулна.

21 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Энэ хууль болон энэ хуультай уялдан гарсан аливаа хэм хэмжээний актыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг Зөрчлийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

21.3.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....-ний өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан Байгалийн ургамлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн ургамлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....ний өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14.1 дэх хэсгийн хүснэгт, 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтын “ургамал” гэсний дараа “, тэдгээрийн түүхий эд” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19.1.2 дахь заалтын “ховор” гэснийг, 19.1.3 дахь заалтын “хадлан” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, 19.1.4 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Байгалийн ургамлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....ний өдөр

Улаанбаатар хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсаныг нэмсүгэй.

38.9. Ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, тархац нөөц тогтоох, гадаад улсад гаргахтай холбоотой асуудлыг Байгалийн ургамлын тухай хуулиар зохицуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн ургамлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....ний өдөр

Улаанбаатар хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“21 дүгээр зүйл

21.1.15.элбэг ургамал, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх зөвшөөрөл олгоход тухайн үеийн жингийн килограмм тутамд 2500-3000 төгрөг;

21.1.16.нэн ховор ургамал, тэдгээрийн түүхий эдийг судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглах, гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход тухай үеийн жингийн килограмм тутамд газрын дээд хэсэг 30 000-50 000 төгрөг, газрын доод хэсэг 45 000-55 000 төгрөг;

21.1.17.ховор ургамал, тэдгээрийн түүхий эдийг судалгаа шинжилгээний болон эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход тухай үеийн жингийн килограмм тутамд газрын дээд хэсэг 6000-8000 төгрөг, газрын доод хэсэг 8000-10 000 төгрөг, судалгаа шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход тухай үеийн жингийн килограмм тутамд газрын дээд хэсэг 15 000-25 000 төгрөг, газрын доод хэсэг 20 000-30 000 төгрөг;

21.1.18.элбэг ургамлыг судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход тухай үеийн жингийн килограмм тутам 1800-4500 төгрөг.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Байгалийн ургамлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....ний өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "ахуйн" гэсний өмнө ", судалгаа шинжилгээний" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.1.1.Байгалийн нэн ховор, унаган ургамал тэдгээрийн түүхий эдийг судалгаа шинжилгээний, ховор ургамал, тэдгээрийн түүхий эдийг ахуйн хэрэгцээнд;

1.1.2.Элбэг ургамал тэдгээрийн түүхий эдийг ашиг, орлого олох болон үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Харь зүйл ургамлыг байгальд тарималжуулсан, тархаасан эсхүл зөвшөөрөлгүй гадаадад гаргасан, гадаадаас оруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

3 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн ургамлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
....ний өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “үр эрхтэнийг” гэснийг “түүхий эдийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Байгалийн ургамлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

ГАРЧИГ

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийх

- 1.1. Асуудлын хамрах хүрээг тогтоох
- 1.2. Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлох
- 1.3. Асуудал үүсгэж буй учир шалтгааныг тогтоох

Хоёр. Зорилгыг томьёолох

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах

- 3.1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг сонгох
- 3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг, сөрөг талыг үнэлэх
- 3.3. Харьцуулалтад үндэслэж хамгийн үр дүнтэй хувилбарыг тогтоох

Дөрөв. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах

- 4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 4.2. Эдийн касагт үзүүлэх нөлөө
- 4.3. Нийгэмд үзүүлэх нөлөө
- 4.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Тав. Дүгнэлт, зөвлөмж

ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулга)

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, бэлчээрийн зохисгүй ашиглалт, уул уурхайн үйл ажиллагаа, орчны бохирдол зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалж цөлжилт, байгалийн ургамлын нөөц багасах, төрөл зүйл устах аюул бодитоор тулгараад байна.

Өдгөө Монгол орны ургамлын аймагт 108 овгийн 684 төрлийн 3160 зүйл гуурст дээд ургамал бүртгэгдсэнээс унаган ургамал 153, завсрын унаган 458, нэн ховор 133, ховор 356 зүйл, үлдэц (үлдвэр) ургамал 70 зүйл ургамал бүртгэгдээд байна.¹ Эдгээр 3160 зүйл гуурст дээд ургамалд тодорхой шалгуураар үнэлгээ хийхэд 1472 зүйл ургамал буюу нийт ургамлын 46%-ийг зайлшгүй хамгаалалтад авах шаардлага үүсээд байна.² Мөн Монгол орны бэлчээр нутгийн 70 гаруй хувь нь аль нэг байдлаар доройтсон нь³ мал бэлчээрлэлт ургамлын үрийн нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлж, ургамлын бүлгэмдлийн бүрэлдэхүүн, бүтцэд ихээхэн өөрчлөлт оруулж ургамлын баялаг хомсдох нэг шалтгаан болж байна. Байгалийн ургамлын ховордлын шалтгааны 59,3% нь хүний нөлөөгөөр, 38,6% нь нөөцийн хэт ашиглалтаас, 47,3% нь байгалийн гамшгаас үүдэлтэй байна.⁴

Дэлхий дахинд экологийн тэнцлийг хангах, биологийн төрөл зүйлийн хомсдолыг хязгаарлан зогсоох, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг сайжруулах асуудал хурцаар тавигдаж байгаа өнөө үед ялангуяа бэлчээр нутгийн 70 гаруй хавь нь цөлжөөд байгаа бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг манай орны хувьд байгалийн ургамлыг хамгаалах, зүй зохистой ашиглах асуудал нь маш чухал юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”⁵, “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах,

¹ Urgamal et al.2016

² Species catalogue of rare and threatened vascular plants of Mongolia M.Urgamal, 2018

³ Монгол орны байгаль орчин IV боть

⁴ Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид), Ц. Жамсран, Ч. Санчир, С. Бахман, Н. Сонинхишиг, С. Гомбобаатар, Ж.Е.М. Баиллие, Ц. Цэндээхүү (редакторууд) (2012). Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг.

орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй"⁶, "... байгаль орчныг хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн"⁷ хэмээн хуульчилж улмаар 1995 онд Байгалийн ургамлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2016-2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд⁸ Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж 2018 онд батлуулна гэж тус тус заасан.

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг.

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 2 дахь хэсэг.

⁸ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоол.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл боловсруулах асуудал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн⁹ 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг болон Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹⁰/цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд байгаль орчны эрх зүйн орчинг сайжруулах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, менежментийг боловсронгуй болгох талаар бодлогын баримт бичигт тусгалаа олж, хэрэгжүүлэх талаар тодорхой үр дүнд хүрч байгаа боловч Байгалийн ургамлын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдээгүй, бодлого арга хэмжээг олон улсын жишигт нийцүүлэх, шинэчлэн зохион байгуулах, менежментийг сайжруулах, хэрэгжилтийг хангах, иргэдийн оролцоо болон хяналтыг дэмжих, хамтран ажиллах тогтолцоо сул байгаагаас байгалийн ургамлыг хамгаалах, нөөцийн хомсдолыг хязгаарлан зогсооход төдийлөн ахиц гарагчийг байна.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, орон нутгийн захиргаанаас нөхцөл байдлын талаарх тайлан, лавлагaa, статистик тоон мэдээлэл цуглуулах, мөн асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийх, эрх зүйн акт, энэ асуудлаар өмнө хийгдсэн судалгаа, мэдээлэл, тодорхой тохиолдлыг судлах хэлбэрээр тоон болон чанарын мэдээлэл цуглуулсан болно.

➤ Эрх зүйн зохицуулалт болон практик хэрэгжилтийн байдал:

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Байгалийн ургамлын тухай хууль 1995 онд батлагдсан бөгөөд 1995 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Энэхүү хууль нь ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулсан төрөлжсөн хууль бөгөөд батлагдсанаас хойш нийт 4 удаагийн¹¹ нэмэлт өөрчлөлт орсон боловч

⁹ Төрийн мэдээлэл эмхтгэл. № 25. 2015 он.

¹⁰ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

¹¹ 1997.01.16, 2002.06.07, 2010.12.09, 2015.12.04-ний едрийн хуулиар.

зарчмын шинжтэй, зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дорвитой өөрчлөлт ороогүй байна.

Байгалийн ургамлын тухай хуульд ой болон таримал ургамлаас бусад асуудлыг зорхицуулна гэж оруулсан, Ойн тухай хуулийн З дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт "Ой" гэдэг нэр томьёоны тодорхойлолтонд ой гэж мод, бут, сөөг болон бусад ургамал гэж заасан нь байгалийн ургамлын тухай хуулийг бүхэлд нь хамрах байгаа мэт харагдуулж байна. Мөн Монгол орны нийт газар нутгийн 9%-ийг ойн сан бүхий газар эзэлж Монгол оронд бүртгэгдээд байгаа 7350 зүйл дээд, доод ургамлын тодорхой хувь нь ойн сан бүхий газарт байдаг учраас энэ хуулийн зохицуулалтаар ойг зохицуулахгүй байх боломжгүй юм.

Мөн тариамал ургамлыг энэ хуулиар зохицуулахгүй гэсэн нь байгалийн ургамлыг тарималжуулан ашиглах Засгийн Газрын болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны бодлоготой нийцэхгүй, Байгалийн ургамлыг тарималжуулах асуудлыг одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6.3, 6.4 дэх хэсгээр зохицуулж байгаа ч одоогийн үүсээд байгаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа юм.

Эндээс үзэхэд байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлуудыг олон улсын жишиг болон үүсээд байгаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага гарч байна.

Байгалийн ургамлын тухай хуульд байгалийн ургамлыг хамгаалах асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулахаар заасан нь одоогийн нөхцөл байдалд учир дутагдалтай, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байлыг үүсгээд байна.

Монгол орны ургамын аймагт бичил биетнийг оруулсан байгаа нь зохимжгүй бөгөөд Бичил биетэн ангилал зүйн бие даасан салбар тул байгалийн ургамлын тухай хуулиар зохицуулах боломжгүй юм.

Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглоно гэж заасан нь эмзэг экосистемтэй манай орны хувьд харь зүйл ургамлыг зөвшөөрлийн үндсэн дээр ч байгальд таримлажуулах нь зохимжгүй юм.

Байгалийн ургамлын тухай хуулийн 15.1-д үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулах үүрэгтэй тул энэ заалтыг өөрчилж, бодлогын баримт бичигт боловсруулах хэмжээний

судалгааг шинжлэх ухааны төв байгууллагатай хамтран явуулах болгон өөрчлөх шаардлагтай байна.

Байгалийн ургамлын тухай хуулийн 10 дугаар зүйлд ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглаж болно гэж заасантай ховор ургамлыг үйлдвэрлэлийн зориулатаар түүж бэлтгэж байгаа нь зөрчилдөж байна. Мөн ховор ургамлын зөвхөн эм үйлдвэрлэлд ашиглана гэдэг заалт хэрэгждэггүй тул үүнийг одоогийн нөхцөл байдалд тохируулан бодлогын баримт бичигт өөрчлөх хэрэгтэй.

Ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны 50 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тухайн ургамлыг тарималжуулдаггүй, ургамал нөхөн сэргээсэн талбайгаа тухайн сум орон нутагтаа хүлээлгэж өгдөггүй ямар нөхөн сэргээлт хийнэ гэж заасан байдаг боловч ямар нөхөн сэргээлт хийх нь тодорхойгүй байдаг учраас энэ заалт хэрэгжихэд хүндрэлтэй.

Бэлчээр, хадлангийн ургамлыг зөвхөн мал тэжээх зориулалтаар ашиглах хуулийн зохицуулалт байгаа боловч Гаалийн ерөнхий газрын мэдээгээр хадлангийн зориулалтаар бэлтгэсэн өвс нэрийн дор их хэмжээгээр бэлтгэж, улсад байгалийн нөөц ашигласны төлбөр огт төлөлгүй БНХАУ руу 2016-2017 онд 176.1 мянган тонн байгалийн ургамал гарсан байна. Ийм учраас энэ заалтын хэрэгжит хангальгүй хадлан нэрийн дор их хэмжээний байгалийн ургамал, Монгол орны генетик нөөц гадагш гарч байна. Мөн бэлчээр, хадлангийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар хадаж бэлтгэхэд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож үүнд тохирсон байгалийн нөөцийн төлбөр, тэмдэгтийн хураамжийн татварын бодлого боловсруулах нь зүйтэй байна.

Тус хуулийн 17.4 дэх хэсэгт "...ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно" гэж заасан хэдий ч "эцсийн бүтээгдэхүүн" гэж юуг хэлэх тухай зохицуулалт одоог хүртэл байхгүй байна. Иймд гадаад зах зээлд эрэлт ихтэй үндсийг нь ашигладаг ховор ургамлыг байгалиас нь түүж бэлтгэх бодлогод өөрчлөлт оруулж, зөвхөн тарималжуулсан бол гадаадад гаргах бодлогоор зохицуулж, төрөөс урамшуулж татварын хөнгөлөлттэй нөхцөл байдал үзүүлэх шаардлагатай байна.

Судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах ургамлын хэмжээг Засгийн газар тогтооно гэж заасан хэдийн ч судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах ургамлын хэмжээг тогтоосон засгийн газрын тогтоол байхгүй. Судалгаагаар гарах ургамлын төрөл, зүйлийн хэмжээг Засгийн газрын тогтоолоор батлуулах боломжгүй тул үүнийг асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага журмаар зохицуулах хэрэгтэй.

Мансууруулах бодис бүхий ургамалтай холбоотой зохицуулалтыг Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хууль болон Монгол орны нэгдэн орсон олон улсын конвенцийтой уялдуулах.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Холбогдох тайлангаас үзэхэд байгалийн ургамлыг хамгаалах, зүй зохистой ашиглах, санхүүжүүлэх асуудал тогтвортой бус, иргэдийн төдийгүй орон нутгийн удирдлагын харилцан уялдаа холбоо сул, ёс төдий байдал түгээмэл болж, дараах бүлгийн эрх ашигт сергээр нөлөөлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийт иргэд	Байгалийн ургамлын зүй бус ашиглалтаас үүдэлтэй бэлчээрийн доройтол ихээр үүсч нийт газар нутгийн 76,8 ¹² хувь нь цөлжилтөд өртөөд байна. Өөрөөр хэлбэл, улс орны аюулгүй байдал, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд төдийгүй эдийн засгийн хөгжилд сергээр нөлөөлж байна.
2	Орон нутгийн иргэд	Байгальд учирсан хохирлын сөрөг үр дагаварт тухайн орон нутгийн иргэд хамгийн ихээр өртөнө. Энэхүү эрсдэлт байдал нь амьдрах орчин төдийгүй ядуурал, ажилгүйдлээс үүдэлтэй шилжин суурьшилт, уугуул иргэдийн соёл, уламжлалаа алдах зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгоно.
3.	Төр/төрийн албан хаагч	Төрөөс байгалийн ургамлыг хамгаалах ажилд дангаар хяналт тавьснаар хяналт хүртээмжгүйн улмаас ачаалал үүсгэх, улмаар үйл ажиллагааг үр дүнгүй болгоход хүргэж байна. Энэ байдал нь эргээд байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээхэд улсын төсвөөс ихээхэн зардал шаардагдахад хүргэж байна.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас байгалийн ургамлыг хамгаалах, тэдгээрийг зүй зохистой ашиглахад иргэдийн оролцоо хяналт хязгаарлагдаж, төр, иргэн, төрийн бус байгууллагуудад давхар зардал үүсгэх, иргэдийн төрд итгэх итгэл алдагдах, хүнд суртал, чирэгдэл, дур зоргоор авирлах байдлыг нэмэгдүүлж болзошгүй байна.

¹²www.iec.mn цахим сайтын Цөлжилтийн мэдээллийн сан хэсэг

Байгалийн ургамлыг хамгаалах ажилд иргэд, иргэдийн нөхөрлөл, хуулийн этгээдийг татан оролцуулж хамтын түншлэл бий болгож, хамгаалалтын үйл ажиллагааг өргөжүүлж, тогтвортой, хариуцлагатай ажиллуулах нь:

- Байгалийн ургамал хамгаалах ажилд иргэд, аймаг гийслэлийн засаг дарга оролцох, санал, санаачилгаа төрийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх, үр шимиийг нь ард иргэд хүртэх боломж нэмэгдэнэ;
- хяналтын тогтолцоо цогц болж, төрийн ачаалал, зардал буурна;
- олон нийтийн хяналт тогтолцоо бүрдэнэ;
- нутгийн уугуул, ялангуяа уламжлалт аргаар мал аж ахуй иргэдийн зохион байгуулалт сайжирч, нутгийн бэлчээр, байгалийн ургамлыг зөв зохистой ашигладаг болно;
- орон нутгийн иргэд нийгэм, эдийн засаг, байгаль орчны аливаа бэрхшээлтэй асуудлыг хохирол багатай, хамтран даван туулах боломж бүрдэнэ;
- ажлын байр, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх зэргээр орон нутгийн иргэдийн амьжиргаа дээшилж, улмаар хэт төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэх;
- иргэдийн амьжиргааны өөр эх үүсвэр олоход дэмжлэг үзүүлнэ;

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг асуудлын цар хүрээ, эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдтэй хамааралтайгаар тодорхойлсон бөгөөд холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд “Байгалийн ургамлын”-ын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй олон бэрхшээл, маргаантай асуудал байсаар байна.

Эдгээрийг тоймлон үзвэл:

- Хуульд байгалийн ургамлыг хамгаалах асуудлыг тодорхой тусгаагүй, байгаль орчныг хамгаалах хуулиар зохицуулах ерөнхий заалтаар оруулсан байгаа нь орон нутгийн болон төрийн захирагааны төв байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо сул, төлөвлөлт хэрэгжилт хангалтгүй, хариуцлага хяналтын тогтолцоог байхгүй болгож байгалийн ургамал тэр дундаа нэн ховор, ховор ургамлыг хамгаалах асуудал орхигдож байна;
- Байгалийн ургамлыг хамгаалах, байгалийн ургамлын нөөцийн зохистой ашиглалтыг зохицуулах, менежментийг өөрчлөн сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Хамгаалалт, санхүүжилтийг төр дангаар хариуцдаг тогтолцоонос хувийн хэвшил, төрийн бус байгууллага, нутгийн иргэдийн

оролцоог хангах замаар хамтын менежментийн шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх хууль зүйн зохицуулалт шаардлагатай байна;

- Байгалийн ургамлын нөөцийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг ургамал түүж бэлтгэсэн ААН байгууллага хийж нийцэтгэнэ гэж заасан байгаа ч ямар нөхөн сэргээлт хийх нь тодорхойгүй байна;
- Байгалийн ургамлыг тарималжуулан ашиглах асуудлыг хуульчлаагүй учраас тарималжуулсан нэрийн дор байгалийн ургамлыг ашиглах явдал бий болох, байгалиас үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэх зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Иймд энэ талын харилцааг тодорхой зохицуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаар ургамал хамгаалах, зохистой ашиглах, түүний унаган төрхийг алдагдуулахгүй нөхөн сэргээх нөхцөл бүрдэнэ.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна:

Зорилго "Байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх менежмент сайжирч шинэ шатанд гарах"

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу "Байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх менежмент сайжирч шинэ шатанд гарах" зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1 Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх зорилгод боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ. Цаашид тулгамдсан асуудал нэмэгдэх болно.	Үр дүн сөрөг

2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй ч иргэдийн идэвх, хяналт тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай. Гэхдээ энэ нь асуудлыг сайжруулах нэг хэлбэр болохоос асуудлыг бүрэн шийдвэрлэх хувилбар биш.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй .	Дангаараа үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Тодорхой тохиолдолд татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, урамшуулах нь үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой ч тогтвортой байж чадахгүй. Түүнчлэн байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх санхүүжилт, хамтын ажиллагааг бүрэн хангах боломжгүй юм.	Зардал шаардагдана. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Байгалийн ургамлыг хамгаалах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлд төрөөс шууд мөнгөн дэмжлэг үзүүлэх нь зарим талаар үйл ажиллагааг дэмжих хэдий ч түр зуурын арга хэмжээ тул зорилгыг хангаж чадахгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Байгалийн ургамлдыг хамгаалах, цөлжилтийг бууруулах, байгалийн ургамлын нөөцийн хомсдолыг зогсооход иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй

		оролцуулах хуулиар хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, ажиллах нийтлэг журмыг батлан мөрдүүлэх (Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх) асуудлыг хуулийг хэрэгжүүлэх боломжгүй юм.		
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Байгалийн ургамлын тухай хуулийг шинэчлэн боловсруулснаар байгалийн ургамлыг хамгаалах, байгалийн ургамал ашигласны төлбөр, байгаль орчин учруулсан хохирлын тодорхой хувийг эргээд байгалийн ургамлыг нөхөн сэргээхэд зарцуулах хуулиар хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, ажиллах нийтлэг журмыг батлан мөрдүүлэх боломж бүрдэнэ.	Зардал гарах боловч гарч болох зөрэг үр дүнтэй харьцуулахад бага байх бөгөөд энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлыг зохицуулалтгүй орхих, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс шууд мөнгөн дэмжлэг үзүүлэх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй юм.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн зохицуулах харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилтод хүрэхийн тулд Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилэх буюу хуулийн төслийг боловсруулах хувилбарыг сонгож байгаа тул Аргачлалын 5.5-д заасны дагуу тандан судлах ажиллагааг үргэлжлүүлж, тодорхойлсон зорилгын дагуу түүнд хүрэх дараах зохицуулалтын хувилбарыг дэвшүүлж байна:

- ✓ Хувилбар 1. "Байгалийн ургамлын хамгаалалтын менежментийн зохицуулалтыг бүрдүүлж орон нутгийн засаг захиргааны байгууллага, иргэдийн ололцоог нэмэгдүүлэх"

- ✓ Хувилбар 2. Байгалийн ургамлын хамгаалалтын зохицуулалтыг бүрдүүлж хуулийн этгээдтэй гэрээ байгуулах замаар хамгаалалтын асуудлыг шийдвэрлэх”

Нэгдүгээр хувилбарын хувьд байгалийн бүс бүслүүрийн онцлогыг харгалзан байгалийн ургамлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хувилбарыг бий болгосноор нэг талаас даяаршин буй дэлхий нийтийн жишгийг хангах нөгөө талаас энэ талаар гарсан бодлогыг хэрэгжүүлэхэд дөхөм болохыг олон тооны судалгаа нотолж байна.

Байгалийн ургамлыг хамгаалахад өнөөдрийн хэрэгжиж байгаа хууль эрх зүйн орчин нь практикийн дагуу үргэлжлүүлэн хийх боломжгүй юм.

Харин байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг татан оролцуулсанаар бага зардлаар ихээхэн үр дүнд хүрэх боломжтой болно.

Хоёрдугаар хувилбарын хувьд байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээхэд зөвхөн хуулийн этгээдийг татан оролцуулж гэрээний үндсэн дээр хамгаалах, нөхөн сэргээх нь хувь иргэн, иргэдийн сайн дурын бүлгийг оролцуулах боломжоор хязгаарлах болгож байна.

Ингэснээр Үндсэн хуулийг зөрчих магадлагатай үзэж болохоор байна. Нөгөө талаар тухайн нутаг дэвсгэр оршиж байгаа иргэдийн төрд итгэх итгэлийг алдагдуулах, байгаль орчны мэргэжлийн байгууллагыг оролцуулах боломжгүй болж байна.

Мөн олон тооны хуулийн этгээд бий болох үүнийг дагаад хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх, тамга тэмдэг авахаас эхлээд нэлээдгүй зардал гарах нь ойлгомжтой.

Иймд нэгдүгээр хувилбар, эрх зүйн зохицуулалтын хувьд ч, эдийн засгийн үр өгөөжийн хувьд илүү үр дүнтэй харагдаж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс дэлгэрэнгүй үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хамтын менежментэд тулгуурлан орон нутгийн захиргаа, иргэдийн нөхөрлөл аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн орчныг тодорхой тогтоож, эрх, үүргийн нь тодорхойлж, хариуцлагыг нэмэгдүүлэх нь байгалийн ургамлыг хамгаалах чиглэлд төртэй хамтарч буюу нөхөж ажиллах үндэсний нөөц бүрдэж, энэ чиглэлд иргэдийн хяналт сайжирч, улмаар иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмж, чанар дээшлэнэ.

Өөрөөр хэлбэл, хүний эрхийг аливаа хэлбэрээр хязгаарласан бус тэдгээрийг дэмжих, тогтвортой үйл ажиллагаа явуулах, амьжиргаагаа дээшлүүлэхэд томоохон түлхэц болно.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Байгалийн ургамлын тухай хуулиар байгалийн ургамлыг хамгаалах ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дийлэнх хувийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас бүрдүүлж байна.

Харин сонгосон хувилбар нь олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг бий болгосноор төрд үүсэх зардлын болон захиргааны ачааллыг багасгаж, ажил эрхлэлт, бизнес, өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлнэ.

Хэдийгээр тодорхой хүрээнд төсвийн зардлыг нэмэгдүүлэхээр байгаа боловч эцсийн үр дүнд байгалийн ургамлыг хамгаалах, үр ашигтай ашиглалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төрийн хяналт шалгалтын үргүй зардлыг хэмнэх боломжийг бүрдүүлнэ.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын тухайд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, иргэдийн амьжиргааг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх сайн талтай бөгөөд орон нутгийн иргэдийн хувьд өөрсдийн нөөц боломжид тулгуурлан ажлын байртай болох, улмаар орлогоо нэмэгдүүлэх, орон нутгаа хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн үр ашигтай, хяналттай ашиглалтыг бий болгосноор нийт иргэдийн амьдрах орчинд зэрэг нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбар бүгд байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээхэд тогтвортой, үр дүнтэй хяналт, хамгаалалтыг бүрдүүлэхээс гадна энэ чиглэлд иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлж, төрд үүсэх ачааллыг багасгах сайн талтай.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улс нь Үндсэн хуульдаа “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн

хамгаалалтад байна.”¹³, “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”¹⁴, “... байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”¹⁵ хэмээн хуульчилж, улмаар 1995 онд Байгалийн ургамлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улс нь 2016 оны байдлаар хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлд олон талт олон улсын 22 гэрээнд нэгдсэн орсон байна.¹⁶

Байгаль орчны талаарх дараах конвенцэд Монгол Улс нэгдэн орж, хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн:

- ✓ Биологийн олон янз байдлын тухай Конвенц /1993.9.30/;
- ✓ Уур амьсгалын өөрчлөлтын асуудлаарх НҮБ-ын суурь Конвенц /1994.3.21/;
- ✓ Озоны үе давхаргыг хамгаалах тухай /1985/ Венийн Конвенц;
- ✓ Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухайн Монреалын Протокол /1996.3.7/;
- ✓ Ган, цөлжилтэд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенц /1996.9.3/;
- ✓ Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Конвенц /1997.6.5/;
- ✓ Био аюулгүй байдлын тухай Картагены протокол.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү заалтын дагуу байгалийн ургамлын талаар зохицуулж байгаа хууль тогтоомжууд нь агуулга, зарчмын хувьд эдгээр олон улсын гэрээ конвенцтэй нийцсэн байх шаардлагатай бөгөөд харин түүний заалтуудыг заавал хуулбарлан хуульчлах шаардлагагүй юм.

Мөн 1993 онд батлагдсан Биологийн олон янз байдлын тухай Конвенцид “Үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглахад ач холбогдол бүхий амьдралын уламжлалт хэв шинжийг хадгалсан уuguул хүн ам, нутгийн хэсэг бүлэг хүмүүсийн мэдлэг, шинэлэг зүйл, амьдралын туршлагыг хүндэтгэн хамгаалж дэмжих, түүнийг тэдгээр хүмүүсийн оролцоотойгоор дэлгэрүүлж, хэрэглэх боломж олгох, мөн тийм мэдлэг, шинэлэг зүйл, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш шударга зарчмаар хамтран ашиглах явдлыг дэмжих гэж, Биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгийг ex-situ хадгалах арга хэмжээг аль болох тухай орон нутагт хэрэгжүүлэх гэж, амьтан ургамал бичил организмыг ex-situ хадгалах, судлах нөхцлийг аль болох генетикийн нөөцийг эх оронд нь бий болгож хэрэгжүүлэх гэж, устах аюулд орсон

¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1.

¹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2/.

¹⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 2.

¹⁶ www.mfa.gov.mn цахим хуудас. Монгол Улсын нэгдсэн орсон олон талт гэрээ. Сүүлчийн нэвтрэлт 2017-4-18-ны өдөр.

төрөл зүйлийг нөхөн сэргээх, тэдгээрийг амьдардаг байгальд нь нутагшуулах ага хэмжээ авах”¹⁷ гэжээ.

Иймд Хуулийн төслийн хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй бөгөөд харин тэдгээрийн хууль зүйн хувьд хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд чухал нелөө үзүүлэх юм.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Олон улсын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд байгаль орчныг хамгаалахад байгалийн жам ёсны шүтэлцээг хангах нь сонгодог хэлбэр бөгөөд хүн төрөлхтний байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэх чухал ага гэдгийг НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн тунхаглал”, “Дэлхийн тунхаглал”, “Тогтвортой хөгжлийн ХХI зууны үйл ажиллагааны хөтөлбөр” /НҮБ/, Байгаль орчин ба хөгжил” дэлхийн бага хурал. Рио-де Жанеро /1992/, Тогтвортой хөгжлийн талаарх Йоханнесбургийн тунхаглал, Йоханнесбург/2002/ зэрэг баримт бичигт хэмээн тодорхойлжээ.

1. Байгалийн ургамын менежментийг нутгийн иргэдийн хариуцаж буй жишиг

Армен нь Техник, бүтцийн хувьд Байгалийн ургамлын хуультай төстэй “Ургамал хамгаалал болон түүний хорио цээрийн тухай” хуультай бөгөөд энэ хуулиндаа ургамал хамгаалал, ургамлын хорио цээрийн зохицуулалт болон зөвшөөрлийн тогтолцоо манай орныхтой төстэй.

ОХУ нь 2002 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулиа шинэчлэн баталсан бөгөөд уг хуульд зааснаар байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах хүрээнд нутгийн иргэдийн оролцоог хангах, тэднийг урамшуулан дэмжих зохицуулалтыг тусгасан байна.

БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хуулиа 1989 онд баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд байгаль орчныг хамгаалах хуулиндаа 2014 онд анх удаа нэмэлт өөрчлөлт оруулж, байгаль орчныг бохирдуулж байгаа этгээдэд оногдуулах шийтгэлийг төдийгүй хуулийг хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудыг албан тушаал бууруулах болон ажлаас нь халах гэх мэт ага хэмжээнүүд нэмж тусгасан байна.

Мөн БНХАУ нь зэрлэг ургамлын нөөцийг хамгаалах, хөгжүүлэх, зүй зохистой ашиглах, биологийн олон төрөлт чанар, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор баталсан бөгөөд дараах бүтэцтэй. 1 дүгээр булэг. Ерөнхий журам, 2

¹⁷ Териийн мэдээлэл, Биологийн олон янд байлын конвенци. 2010 он.

дугаар булэг. Зэрлэг ургамлыг хамгаалах, 3 дугаар булэг. Зэрлэг ургамлын удирдлага /зөвшөөрөлийн бүтэц/, 4 дүгээр булэг. Хуулийн хариуцлага, 5 дугаар булэг. Бусад

Намиби улс: Зэрлэг амьтныг хамгаалах, ашиглах эрхийг нутгийн иргэдэд шилжүүлсэн тодорхой сайн жишээ болсон улсын нэг. Нутгийн иргэдийн хамгаалагдсан газар (Communal Conservancies) нь 1990 онд хуульчлагдаж, нутгийн иргэдийн нөхөрлөл зэрлэг амьтныг аж ахуйн болон амины зорилгоор ашиглах эрхийг авах боломжтой болсон байна.

Дээрх улсуудын хувьд байгалийн ургамлыг хамтын менежментийн хүрээнд хамгаалах, түүнээс ашиг шимийг хүртэх, ажлын байр бий болгох талаар сайн туршлагатай ба Монгол Улсын тухайд Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хуулиар хамтын менежментийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлсон бөгөөд өөрийн орны онцлогт тохирсон хамгаалалтын, түншлэлийн хамтын ажиллагааг боловсронгуй болгож, хөгжүүлэх боломжтой юм.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

1995 онд Байгалийн ургамлын тухай тухай хуулийн баталж, хэрэгжүүлсэнээр байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нилээдгүй ахиц гарсан байна.

Өнөөдөр, Монгол орны ургамлын аймаг, түүний олон янз байдалд гуурст (оим, нүцгэн болон далд үртэн) болон гуурсгүй (хөвд, замаг, мөөг, хаг) гэх ургамлын үндсэн 2 бүлэг багтдаг бөгөөд олон жилийн судалгааны үр дүнд Монгол оронд одоогоор 19 хүрээнд хамаарах 37 ангийн 116 багийн 388 овогт хамаарах 1523 төрөлд багтах 7350 зүйл, дэд зүйл бүртгэгдэв¹⁸. Үүнд 56 овгийн 156 төрлийн 574 зүйл, дэд зүйл дээд мөөг; 87 овгийн 268 төрлийн 2003 зүйл, дэд зүйл замаг; 63 овгийн 207 төрлийн 1033 зүйл, дэд зүйл хаг; 74 овгийн 208 төрлийн 580 зүйл, дэд зүйл хөвд; 108 овгийн 684 төрлийн 3160 зүйл, дэд зүйл¹⁹ гуурст ургамал тархсан байна. Байгалийн ургамлыг хамгаалах хойч үедээ өвлүүлэн үлдээх чадамж дэлхий нийтийн жишгээс хол хоцорч байгааг эрдэмтэн судлаачид баталсаар байгаа бөгөөд Байгалийн ургамлын хамгаалалт, зохион байгуулалт, тогтвортой ашиглалт, санхүүжилт, байгалийн ургамлын нөөцийн нөхөн сэргээлтийн менежментийг бий болгох асуудлыг шийдэхгүйгээр ургамлын олон янз байдлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, ургамал хамгааллыг дэлхий нийтийн жишигт хүргэх боломжгүй юм.

Иймд байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх түүний тогтвортой байдлыг хангахад нэг талаас холбогдох төрийн байгууллага нөгөө талаас иргэд, хуулийн этгээд буюу хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог шинэчлэн тодорхойлж хамтын түншлэл, түүнтэй уялдсан хөгжлийн болон хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, нэмэгдүүлэх нь чухал юм. Мөн иргэд олон нийтийг байгаль хамгаалахтай холбоотой шийдвэр гаргахад оролцуулах, тэдний идэвхи санаачлагыг дэмжих, шаардлага байгаа нь харагдаж байна.

¹⁸ Urgamal et al. 2016; Ургамал 2017

¹⁹ (Urgamal et al. 2016; Ургамал 2017; Urgamal 2018)

Монгол Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрөөс экологийн талаар баримтлах бодлого" бодлогын баримт бичгийн 3.1 дэх хэсэгт: "Байгаль орчны бодлого нь байгалийн төрх байдлыг хадгалах, байгалийн болон түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах экологийн даацад нийцуулэн нөөц баялгийг иж бүрэн, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үр өгөөжийг нь ард иргэдэд адил тэнцүү хүртээх нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны эдийн засгийн тогтвортой ёсөлтийг тэтгэн, амьдрах орчныг сайжруулахад чиглэгдэнэ." гэж, 3.3 дахь хэсэгт: "Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэхдээ нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийн хүрээнд амьдралын хэрэгцааг бүрэн хангах, үл нөхөгдөх буюу удаан сэргэдэг нөөцийг гагцхуу улс орны хөгжлийн нэмэлт хүчин зүйл болгон зохистой ашиглах замаар экологийн аюулгүй байдлыг хангах явдлыг чухалчилна." гэж, 3.9.4 дэх заалтад: "ургамлын нөөц, тархац, амьтны тоо, байршил, агуурын нөөцийг нь судалж экологи-эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр аж ахуйн ач холбогдол, ашиглалтын хэлбэр, зохион байгуулалтыг нь бүсчлэн тогтоож, элбэг ургамал, амьтныг байгалийн хэвийн ёсөлт, үржилтийг нь алдагдуулалгүй зохистой ашиглах, ургамал, амьтны гаралтай үнэт түүхий эд, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд өрсөлднө." гэж тус тус заасан.

Мөн дээрхи бодлогын баримт бичгийн эдийн засаг, нийгмийн бодлого, зохицуулалтыг хэрэгжилтийг баталгаажуулах арга хэмжээний хүрээнд 4.3.8 дахь заалтад: "байгалийн баялгийг ашигласны телберийг ашиглагч нь, ... нөхөн төлж, хамгаалдаг байх, экологийн тэнцлийг хангах нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн хувь нэмэр, хандиваа оруулдаг байх ... чиглэлээр эдийн засаг, эрх зүйн зохицуулалтыг хүчтэй болгоно" гэж, 4.3.12 дахь заалтад: "байгалийн баялаг ашигласны үр өгөөжөөр ... байгалийн гамшиг, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс амьдрах орчныг хамгаалж, нөхөн сэргээх чиг, зорилготой экологийн даатгал, санхүүжилтийн бие даасан тогтолцоог аажмаар бүрдүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.3 дахь заалтад: "Монгол Улсын "оршин тогтонохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна." гэж заасан бөгөөд хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал хэсгийн 3.5.3.1 дэх дэд заалтад: "ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөц баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй цогц байдлаар шийднэ." гэж, 4.2.1 дэх заалтад: "Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ." гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д "Байгаль

орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно.” гэж заасан бөгөөд энэхүү хөгжлийг хангах зарчмыг “байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах” гэж тодорхойлжээ. Түүнчлэн уг бодлогын баримт бичигт байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого” бодлогын баримт бичигт байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, байгальд ээлтэйгээр ашиглах, үрэлгэн хэрэглээг багасгах, тэдгээрийн үр өгөөжийн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлэхийн зэрэгцээ хүний аж байдлыг сайжруулж ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах, замаар монгол хүний амьдралын сайн сайхан байдлыг хангах хөгжлийн загварт шилжих хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлсон. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.14 дэх хэсэгт: “Байгалийн баялгаас олж байгаа ашиг, орлогын тодорхой хувь болон учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогыг тухайн нөөцийг нөхөн сэргээх, байгаль орчны бохирдол, доройтлыг арилгахад зарцуулж хэвших” арга хэмжээг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого” гэх 4 дэх хэсэгт: “... байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно.” гэж заасан бөгөөд байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр “...ой, түүний дагалт баялаг, байгалийн бусад нөөц баялгийн ашиглалтын нөөцийг бий болгох...”, “...устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарьж ургуулах ажлыг хөрөнгө, санхүү, татварын бодлогоор дэмжинэ”, 4.2.9.2. “Ашигт ургамлын плантаци байгуулах, өндөр уул, говь, цөлөрхөг хээрийн бүс бүслүүрийн нэн ховор, ховор, ашиглалтад нэн өртөмтгийн зүйлүүдийг тарималжуулж нөөцийг тогтвортой ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлэх” хэмээн тус тус тодорхойлжээ.

Мөн Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.8. “Байгаль орчинг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, ашиглалтын үр өгөөжийг сайжруулна”, 4.2.9. “Устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарьж ургуулах ажлыг хөрөнгө, санхүү, татварын бодлогоор дэмжинэ”, 4.2.9.2. “Ашигт ургамлын плантаци байгуулах, өндөр уул, говь, цөлөрхөг хээрийн бүс бүслүүрийн нэн ховор, ховор, ашиглалтад нэн өртөмтгийн зүйлүүдийг тарималжуулж нөөцийг тогтвортой ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлэх” хэмээн тус тус тодорхойлжээ.

Иймд эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээг цогцоор шийдвэрлэх боломжийг нээн илрүүлэх зорилгоор хийсэн энэхүү тандан судалгааны дүнд Байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажиллагааг илүү өргөжүүлж, идэвхитэй, тогтвортой санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг бий болгохын тулд Байгалийн ургамлын тухай хуулийг шинэчлэн боловсруулах буюу хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж Дүгнэж байна.

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн холбогдох хэсгийг харьцуулан байгалийн ургамлыг хамгаалах менежментийг сайжруулах, хамгаалалтын тогтолцоонд төр, иргэн, хуулийн этгээдийн хамтын түншлэлийг бий болгох, судалгаанд үндэслэсэн дараах зөвлөмжийг боловсрууллаа:

Хуулийн төслийг боловсруулахдаа хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай байгаа асуудлын цар хүрээнд тохируулан дараах зарчмын шинжтэй асуудлыг тусгах нь зүйтэй гэж Зөвлөж байна:

- ✓ *Байгалийн ургамлын хамгааллын асуудлыг Биологийн олон янз байдлын концепциейтой уялдуулж *in-situ*, *ex situ* орчинд хамгаалах асуудлыг оруулах*
- ✓ *Үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн газарт нөхөн сэргээлт хийх шаардлагатай гэж оруулсан боловч нөхөн сэргээлт хийх арга аргачлал байхгүй байна. Иймд энэ асуудлыг толдорхой болгон хуульчилж оруулах*
- ✓ *Байгалийн ургамлыг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх асуудлыг бодлого, нийгэм, эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн өөрчилж, хамгаалах шалгуур үзүүлэлтийг тогтоох;*
- ✓ *Эксистемийг унаган тархийг алдагдуулахгүй байх үүднээс харь зүйл ургамлын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн зохицуулалт хийх;*
- ✓ *Байгалийн ургамлын нөөцийн ашиглалтыг тухайн ургамлын нөөцийн судалгаа, экологи-эдийн засгийн үнэлгээнд үндэслэн, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх харилцааг бүрдүүлэх;*
- ✓ *Байгалийн ургамал хамгаалах санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг боломжит хэмжээгээр тодорхойлж, нэмэгдүүлэх. Ингэхдээ бусад хуулийн уялдаа холбоог хангаж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах .*
- ✓ *Байгалийн ургамлын олон янз байдал, түүний хамгааллыг төрөөс баталгаажуулж, төрөл бүрийн орлогын эх үүсвэрийг бий болгож, менежментэд оролцогч талуудыг төрийн бодлогоор дэмжин урамшуулдаг тогтолцоог нэвтрүүлэх.*
- ✓ *Хууль тогтоомж, Байгаль орчинд ноцтой хохирол учруулсан Хариуцлагатай холбоотой нөхөн төлбөрийн асуудлыг зөрчлийн хуульд тусгах арга хэмжээ авах.*

- ✓ Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг зөрчлийн хэм хэмжээнд нь тохируулан тусгах.
- ✓ Байгалийн ургамлын тухай хуулийг шинэчилж байгаатай холбогдуулан бусад хуульд орох нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах.

-----оо-----

I.Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага

1. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2013-2014 он.
2. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2015-2016 он.
3. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2017-2018 он.
4. Биологийн олон янз байдлын хамгааллыг тодорхойлох дүн шинжилгээ (gap analyse of biodiversity)-ний тайлан.
5. www.eic.mn
6. Байгалийн ургамлын мэдээллийн сан
7. Монгол орчны байгаль орчин 5 боть
8. Биологийн олон янз байдлыг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд шатны тайлан
9. CITES-ийн үндэсний тайлан 2019
10. БНАТөлбөрийн 5 жилийн тайлан.

II.Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Байгалийн ургамлын тухай хууль
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
6. Эрүүгийн хууль;
7. Зөрчлийн тухай хууль;
8. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.
9. Биологийн олон янз байдлын тухай конвенци (1993-09-30)
- 10.Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (1996-01-05)
- 11.Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002
- 12.Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002
- 13.Жагсаалт батлах тухай Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол
- 14.Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 1997-12-26 дугаар 106)

15. Тогтоолд нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2004 оны 165 дугаар тогтоол
16. Хуш модны самрын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Засгийн газрын 2011 оны 250 дугаар тогтоол
17. Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийг ашиглах журам (БОАЖС 2015 оны 166 тушаал)
18. Жагсаалт батлах тухай Байгаль Орчны Сайд, Эрүүл мэндийн сайд 1995 оны 139/A/148 хамтарсан тушаал)
19. Монгол орны зарим ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай (БОС 2008 оны 194 тушаал, БОАЖС 2011 оны А-415 тушаал, БОНХС 2015 оны 282 тушаал)

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх		1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
		1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төслөөр холбогдох этгээдэд тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчлагдсан.
		1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Нийтийн ашиг сонирхлын үүднээс тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
		1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнийг шударга, иргээдэд болон байгаль орчинд ээлтэй байх зарчимд тулгаарлан сэргэ үр дагаварыг буруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэнэ.
1.2. Оролцоог хангах		1.2.1.Зохицуулалт ын хувилбарыг сонгоходоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, зэрэг эрх, ашиг сонирхол нь хөндөгдэж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж оролцоог хангасан.

	боломжийг бүрдүүлсэн эсэх			
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалт ыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах менежментэд төр, хувийн хэвшил хамтарсан үйл ажиллагааны шинэ хэлбэрийг үр дүнтэйгээр нэвтрүүлж, олон нийтийн оролцоог хангах замаар байгалийн ургамлыг хамгаалах менежментийг олон улсын жишигт нийцүүлснээр, тэдгээрийн байгаль, нийгэм, эдийн засгийн үр өгөөж нэмэгдэнэ.
	1.3.2. Зохицуулалт ын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хууль зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэн зохицуулна.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр иргэдийн байгалийн нөөц ашиглах

				эрхэнд тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	<ul style="list-style-type: none"> • Иргэн • Нутгийн оршин суугч • Хуулийн этгээд • ТББ
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Нутгийн оршин суугчид малчид болон байгалиас шууд хамааралтай ажил хөдөлмөр эрхэлдэг бусад иргэдийг тодорхой нөхцөл шалгуурын дагуу үйл ажиллагаа явуулах боломжийг тодорхойлж өгсөн.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төслийн зохицуулалтууд иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд, тэдгээрийн эрх зүйн байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх зэрэг иргэдэд тэгшээр үйлчлэх, мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа болон хуулийн этгээд, ТББ-уудад боломж олгоно.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр, хуулийн этгээд үүрэг хүлээнэ.

4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хүйсээр ялгаварлахыг хориглох агуулга давхар тусгагдана.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төслийн зохицуулалтууд бүхэлдээ жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн.

**ЭДИЙН ЗАСГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх			
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хургэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарагчий
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Иноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгааллалттай газар нутагт байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар судалгаа шинжилгээ хийх боломж бурдэнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх сайн талтай.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Иргэн, хуулийн этгээдтэй гэрээний дагуу хамтран ажилласанаар түр болон байнгын ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль	Тийм	Үгүй	Тухайн орон нутагт байгальд ээлтэй жижиг,

	нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх			дунд үйлдвэрлэл хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Байгалийн ургамлын менежментийг хамтран хэрэгжүүлсэнээр төрд үүсэх зардлын ачаалал тодорхой хэмжээгээр буурах бөгөөд төсвийн хэмнэлт гарна. Төрд тодорхой зардлын ачаалал үүсгэх хэдий ч гараг үр дүнтэй харьцуулахад төдийлэн их бус байна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро здийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр бий болгохгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн иргэд, малчид, байгалийн үр шимийг шууд хүртэгчдэд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүсийн сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	булэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт			
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зөвхөн нөлөө үзүүлнэ. Мөн төрийн зүгээс тавих хяналт сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зөвхөн нөлөө үзүүлнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Байгахлийн ургамлдыг хамгаалах, зохицой ашиглах менежментийг нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус болон мэргэжлийн байгууллагад хариуцуулан хамгаалуулах эрх зүйн орчин бүрдсэнээр төрийн ачаалал багасч, байгаль хамгаалалд төр хувийн хэвшлийн хамтын түншлэл бий болно.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрахад зөвхөн нөлөө гарна.

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч зэрэг нөлөө гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх явц

				сайжирч, эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн оролцоо, санаачлагыг нэмэдүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулах зерэг нөлөөтэй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Амьтан, ургамал зэрэг байгалийн тэнцвэрт байдлыг хангахад зерэг нөлөө үзүүлнэ.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлэх эсэх	Тийм	Үгүй	Байгалийн ашигт ургамлыг тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах боломжтой байна.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Хамгаалалтыг сайжруулах зерэг нөлөөтэй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлэх эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутагт сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлэх эсэх	Тийм	Үгүй	Байгалийн ургамал нь усыг тогтоон барих, цэвдэгийг хамгаалдаг тул усны нөөцийг хамгаалахад зерэг нөлөөллийг үзүүлнэ.

	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хамгаалалтыг сайжруулах эерэг нөлөөтэй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хөрсийг нөхөн сэргээх, хамгаалахад чиглэсэн бөгөөд түүнийг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосон зохицуулалттай.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ашиглалт, хамгаалалтад иргэд, төр аль аль нь зэрэгцээ хяналт тавих боломж нэмэгдэж, үр ашиг сайжирна.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн
үнэлгээний тайлан

Онч Шийдэл ТББ
2018 он.

Судалгааны захиалагч:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар

Судалгааны багийн удирдагч:

Ш.Алтангадас

"Онч Шийдэл" ТББ-ийн УЗ-ын дарга



Судалгааг гүйцэтгэсэн:

Ө.Эрдэнэ-Очир

"Онч Шийдэл" ТББ-ийн Гүйцэтгэх захирал, судлаач

А.Зоригтбаатар

"Онч Шийдэл" ТББ-ийн судлаач

Т.Багахүү

"Онч Шийдэл" ТББ-ийн судлаач

Х.Оюун билэг

ХШУДАГ мэргэжилтэн (БОЛДЫГАН)

28 2018

АГУУЛГА:

Товчилсон		үг	1
Нэг. Төлөвлөх үе шат			2
1.1. Үнэлгээ	хийх	шалгаан	2
1.2. Үнэлгээний хийх хүрээ			3
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт			4
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр			4
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох			4
1.6. Мэдээлэл цуглуулах			4
Хоёр. Хэрэгжүүлэх үе шат			5
Гурав.	Үнэлэх	үе	шат
Дөрөв.	Дүгнэлт,		зөвлөмж
4.1. Үнэлэлт, дүгнэлт			17
4.2. Зөвлөмж			17
Ашигласан эх сурвалж			

Товчилсон үг

БОАЖЯ	Байгал орчин, Аялал жуулчлалын яам
БУТХ	Байгалийн ургамалын тухай хууль
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ААН	Аж ахуйн нэгж
УИХ	Улсын Их Хурал

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Байгалийн ургамлын тухай хуулийн (цаашид БУтХ гэх) хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Судалгааны багийн зүгээс үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатаар тодорхойлосон ба зарим тохиолдолд уг асуудлын онцлогоос хамааран энэ дарааллыг баримтлахгүй байж болно.

Төлөвлөх үе шат нь үнэлгээ хийх ажлын суурь бөгөөд үүнд хамаарах алхамуудыг амжилттай гүйцэтгэж чадвал “хэрэгжүүлэх” болон “үнэлэх” үе шатанд хийх ажил илүү тодорхой болно.

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараахь алхамуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:


- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох,
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох,
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох,
- Харьцуулах хэлбэрийг сонгох,
- Шалгуур үзүүлэлтийг томьёолох,
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

БУтХ нь 1995 онд батлагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд энэхүү хуулиар зохицуулах харилцаа багагүй өөрчлөгдөж, энэ төрлийн харилцаанд өөрчлөлт, хөгжлөөс хоцрох хандлага ажиглагдаж, уг хуулийн зохицуулалтуудад бусад хуультай давхардал, хийдэл болон телбер тогтоосон хэмжээ өнөөдрийн нийгэмд шийтгэлийн хэлбэрт үл тохирох, түүнээс улбаалан сөрөг үр дагавар гарах болсон тул хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн болно.

Уг хууль ой болон таримал ургамлаас бусад ургамалыг хамгаалах, зохистой ашиглах, нехэн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой ба үнэлгээ хийх ажлын явцад уг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдтэй хийсэн анкетийн болон ярилцлагын судалгаанд оролцогчдын 17 хүн буюу 95.9 хувь нь энэхүү хуулийг “шинэчлэх шаардлагатай” гэж үзсэн байна.

Зураг 1. Байгалийн ургамлын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага (судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар)



1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээ хийх хүрээг тогтоох зорилгоор судалгааны баг БУТХ-ийн үйлчлэлд хамаардаг зарим субъектээс анкетын судалгаа, мөн захиалагчаас ирүүлсэн өмнөх судалгааны баримт бичгүүдээс харахад оролцогчдын дийлэнх олонхын саналаар Байгалийн ургамлын тухай хуулиар уг хуулийн зорилтыг бүрэн хангаж хэрэгжих боломжгүй, хариуцлагын хэлбэр нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хуулийн үйлчлэлээс дор, уялдаа холбоо муу, зохицуулалтууд нь тухайн харилцаанд өртөгдөх харилцаанаас хоцрогдсон, эдүгээчлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан болно.

Үүнийг харгалзан судалгааны баг уг хуулийн 4 бүлэг 22 зүйлээс 17 зүйлийг өөрчлөх зайлшгүй шаардлагатай ба "нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох хандалгатай болж, түүнээс улбаалан сөрөг үр дагавар гарах болсон" хэмээн үнэлгээ хийх хүрээг тодорхойлсон болно. Эдгээрийг дурдвал:

Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод тусгах 2, Ургамлын сан, түүний ангилал хэсэгт тусгах 5, Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох хэсэгт 2, Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох хэсэгт 2, Бэлчээр, хадлангийн ургамлыг мал тэжээх зориулалтаар ашиглах хэсэгт 1, Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацаа хэсэгт 1, Ургамлыг гадаад улсад гаргах, гадаадын иргэн түүж бэлтгэх хэсэст 2, Мансууруулах бодис бүхий ургамал хэсэгт 2 асуудал байна хэмээн тодорхойлсон болно.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

БУТХ-ийн хэрэгжилтийн судалгаанд судалгааны багийн зүгээс нэгдүгээрт: зорилгод хүрсэн түвшин, хоёрдугаарт: практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр үнэлгээний хүрээ тогтоосон БУТХ-ийн 17 зүйлүүдийн зохицуулалтын зорилго болон зорилтдоо хүрсэн түвшинг харгазлуулан үзлээ. Уг хуулийн 1 дүгээр зүйлээр тодорхойлсон ой болон таримал ургамлаас бусад ургамалыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах гэх зорилтыг хэрэгжүүлэх энэ хуулийн бусад 17 зүйл нь уг зорилттой хэрхэн нийцэж байгааг тодорхойлно.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр хуулийн 17 зүйл нь бүрийн хэрэгжилт, хэрэгжих явцад үүсч буй үр дагавар, хүндэрл бэрхшээл зэргийг тодорхойлно. Уг шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх үүндээс БУТХ-ийн үйлчлэлд хамаарах олон нийтийн төлөөллөөс хэрэгжүүлэхтэй холбоотой тодруулга, санал хүсэлт авна.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалzan **байх ёстой болон одоо байгаа ба тохиолдол судлах хэлбэрүүдийг ашиглав**. БУТХ-ийн зохицуулалтууд байх ёстой болон одоо байгаа хэм хэмжээний харьцуулах хэлбэр нь практикт хэрхэн нийцэж байгааг илрүүлэх зорилготой ба уг нийцлийг баталгаажуулах зорилгоор судалгааны баг **тохиолдол судлах хэлбэрийг ашиглана**.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Уг хэсгийн хүрээнд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ой болон таримал ургамлаас бусад ургамалыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилтод уг хуулийн 17 зүйл хэрхэн нийцэж байгааг тодруулна. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн харилцаанд орж буй төрийн захиргааны байгууллага болон оролцогч бусад этгээдүүд уг хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үдэн гарсан үр дагавар юу вэ, хариуцлагын хэлбэр өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжтой хэр нийцэж буй талаар тодорхойлно.

1.6. Мэдээлэл цуглуулах

БУТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажилд судалгааны багийн зүгээс Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, Холбогдох субъектээс судалгаа авах гэсэн сонгон ашигласан болно. Энэ хүрээнд бэлэн байгаа мэдээллийг цуглуулах БУТХ-ийн холбогдох хууль тогтоомж, уг хуулийн хэрэгжилттэй холбоотой шүүхийн шийдвэр, мэргэжлийн өгүүлэл, илтгэл, судалгааны тайлан, статистик

мэдээнд дүн шинжилгээ хийх, Холбогдох субъектээс судалгаа авах БУТХ-ийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагч, салбарын мэргэжилтнүүдээс судалгаа авах зэрэг.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

БУТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажилд бэлэн байгаа мэдээллийг цуглуулах болон холбогдох субъектээс судалгаа авах аргаар шаардлагатай мэдээллийг цуглуулах.

Нэг. Бэлэн байгаа мэдээлэл

Эрх зүйн баримт бичиг

1. Биологийн олон янз байдлын тухай конвенци (1993-09-30)
2. Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (1996-01-05)
3. Байгалийн ургамлын тухай хууль, 1995
4. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хууль, 1995
5. Ургамал хамгааллын тухай хууль, 1996
6. Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002
7. Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002
8. Жагсаалт батлах тухай Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол
9. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 1997-12-26 дугаар 106)
10. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод сууринсан үндэсний хөгжлийн цогц бодлого (УИХ-ын 1996-07-10 дугаар 163)
11. Тогтоолд нэмэлт оруулах тухай Засгийн газрын 2004 оны 165 дугаар тогтоол
12. Хуш модны самрын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Засгийн газрын 2011 оны 250 дугаар тогтоол
13. Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийг ашиглах журам (БОАЖС 2009 оны 240 тушаал)
14. Ургамал ашиглах зөвшөөрөл олгох эрхийн бичгийн загвар, жагсаалт батлах тухай (БОС 1995 оны 138 тушаал)
15. Жагсаалт батлах тухай Байгал Орчны Сайд, Эрүүл мэндийн сайд 1995 оны 139/A/148 хамтарсан тушаал)
16. Монгол орны ашигт зарим ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай (БОС 2008 оны 194 тушаал, БОАЖС 2011 оны А-415 тушаал)

Хоёр. Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл

БУТХ-ийн хэрэгжилтийн талаар хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Хянал-шинжилгээ, үнэлгээ, дотоод

аудитын газар “Байгалийн ургамлын тухай хууль”-ийн хэрэгжилт болон судлаачдын багийн анкет, ярилцлагын судалгаа.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Өмнөх бүлэгт сонгосон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу БУТХ-ийн 17 зүйлд үнэлгээ хийхэд дараах байдалтай байв. БУТХ нь 4 бүлэг 22 зүйлтэйгээр 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн мөрдөгдсөн, 1997-2015 онуудад 4 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

БУТХ-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд тухайн хуулийн нийт 22 зүйлээс дараахь зүйл заалтуудыг өөрчлөх, бусад хуультай уялдуулах болон шинэчилсэн найруулга хийх шаардлага гарч байна.

Үүнд: Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод тусгах 2, Ургамлын сан, түүний ангилал хэсэгт тусгах 5, Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох хэсэгт 2, Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох хэсэгт 2, Бэлчээр, хадлангийн ургамлыг мал тэжээх зориулалтаар ашиглах хэсэгт 1, Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацаа хэсэгт 1, Ургамлыг гадаад улсад гаргах, гадаадын иргэн түүж бэлтгэх хэсэгт 2, Мансууруулах бодис бүхий ургамал хэсэгт 2 асуудал байна.

БУТХ-ийн 22 зүйлээс 17 зүйл зайлшгүй шинэчлэгдэх шаардлага гарсан тул уг хуулинд шинэчилсэн найруулга хийж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үнэлэв.

ЭДГЭЭРИЙГ НЭГ БҮРЧЛЭН АВЧ ҮЗВЭЛ:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамал /цаашид “ургамал” гэх-/ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хэрэгжилт: Байгалийн ургамлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд ой гэж заасан нь ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дахь хэсэгт “Ой” гэдэг нэр томъёоны тодорхойлолтонд ой гэж мод, бут, сөөг болон бусад ургамал гэж заасан нь байгалийн ургамлын тухай хуулийг бүхэлд нь хамрах байгаа мэт харагдуулж байна.

Дүгнэлт: Байгалийн ургамлын тухай хуулиас “Ой” гэсэн үгийг хасах

2¹ дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1/ "байгалийн ургамал" гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг;

Хэрэгжилт: "байгалийн ургамал" гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг хамруулна гэдэг тайлбараар 2015 оноос хойш хадлангийн зориулалтаар БНХАУ руу 176.1 мянган тонн байгалийн ургамлыг гаргаж байна.

Дүгнэлт: "байгалийн ургамал" гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамал, түүний иш, навч, найлзуур, цэцэг, үр, жимс, үндэс, түүний гаралтай түүхий эд, эрхтэн гэж нарийвчилан зааж оруулах

2/ "байгалийн ургамлын нөөц" гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг;

Хэрэгжилт: "байгалийн ургамлын нөөц" гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг

Дүгнэлт: "байгалийн ургамал" гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамал, түүний иш, навч, найлзуур, цэцэг, үр, жимс, үндэс, түүний гаралтай түүхий эд, эрхтэн гэж нарийвчилан зааж оруулах

3 дугаар зүйл. Ургамлын сан, түүний ангилал

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ.

Хэрэгжилт: Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ гэж заасны дагуу 3127 зүйл гуурст ургамал, 574 зүйл мөөг, 2003 замаг, 1031 хаг, 580 хөвд бүртгэгдсэн байна /Байгаль орчны төлөв байдлыг тайлан 2015-2016 он/. Харин бичил биетний мэдээллийн сан одоогоор үүсгээгүй болно.

Дүгнэлт: Бичил биетэн ангилал зүйн бие даасан салбар тул байгалийн ургамлын сангаас хасах шаардлагатай.

3. Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон /энэ хуулийн хавсралтаар тогтоосон/ ургамал хамаарна.

Хэрэгжилт: Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон /энэ хуулийн хавсралтаар тогтоосон/ 133 зүйл ургамал хамаарна. Нэн ховор 133 зүйл, ховор 15 зүйл ургамлыг олон улсын жишигийн дагуу үнэлгээ хийхэд амьдрах орчинд учруулж байгаа дарамт, хэт ашиглалтын улмаас ургамлын зүйлийн 11% нь устаж байгаа,

26% нь устаж болзошгүй, 37% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15% нь ховордож болзошгүй байна /Монгол орны ургамлын улаан данс 2011/.

4.Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.

Хэрэгжилт: Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор 317 зүйл гуурст ургамал, 2004 оны 165 дугаар тогтоолоор 38 зүйл гуурст ургамал нийт 355 зүйл гуурст ургамал , 11 зүйл хаг, 5 зүйл замаг, 4 зүйл хөвд, 5 зүйл мөөгийн жагсаалтыг баталжээ.

Дүгнэлт: Нэн ховор, Ховор ургамлын жагсаалтанд орсон нийт ургамал дээр олон улсын улаан дансны дагуу үнэлгээ хийж ховор ургамлын жагсаалтыг дахин шинэчлэх.

5 дугаар зүйл. Ургамлын нөөцийн мэдээллийн сан

1.Ургамлын нөөцийн мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ:

- 1/ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ;
- 2/ургамлын хатаамал, бэлдмэл, үрийн цуглуулга;
- 3/ургамлын судалгааны тайлан, мэдээ баримт;
- 4/ургамлын хяналт-шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээ баримт;
- 5/ургамал хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ.

2.Ургамлын мэдээллийн санг бурдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна

Хэрэгжилт: Ургамлын нөөцийн мэдээллийн санг <http://www.eic.mn/flora/> цахим хаяг дээр "ургамлынн аймаг, түүний ангиал", "ургамлын мэдээлэл, нөөц, тархац", "ургамлын улаан данс", "ургамлын улаан ном", "судалгааны тайлан", "экспорт, импортын мэдээлэл", "мэргэжлийн байгууллага", "тарималжуулсан ургамал", "ургамлыг нь ашигласан газрын нөхөн сэргээлт", "хөнөөлт шавьж, ёвчний мэдээлэл", "хяналт шинжилгээний ажиглалт хэмжилт", "хууль эрх зүй", "ашигласан ном хэвлэл" гэсэн ангиллаар мэдээлэл оруулж байна.

Дүгнэлт: Ургамлын нөөцийн мэдээллийн сан гэснийг байгалийн ургамлын мэдээллийн сан гэж өөрчлөх.

6 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн өмчийн газар дахь ургамлыг ашиглахдаа хууль тогтоомжид заасны дагуу төлбөр төлнэ.

2. Ургамал ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг хуулиар тогтооно.

Хэрэгжилт: Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ, 19 дүгээр зүйл Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх хэмжээг хуулиар тогтоосон.

7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах

1. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт: Хээрийн түймэр, үлийн цагаан огтоно, хүр эрвээхэйн нүүдэл зэргээс хамгаалах арга хэмжээг улмын төсвийн хөрөнгөөр хийж байна. Үүнд улсаас нийт хэдэн төгрөг зарцуулдаг талаар мэдээлэл байхгүй болно.

2. Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулах, нутагшуулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага нь ургамлын мэргэжлийн байгууллагын эрхийг З жилээр олгож, сунгадаг. “Байгалийн ургамлын тухай хуулинд үнэлгээ хийх” үүрэг бүхий ажлын дагуу байгалийн ургамлын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийхэд “Бунд-Овоо” ХХК 160 га-д дэрэвгэр жиргэруү ховор ургамал, “Хонгор-Арал” ХХК Монгол хунчир, Сарьслаг хунчир, Байгалийн гүүн хөх, Долгионтсон навчт гишүүнэ, Дэрэвгэр жиргэруү, Урал чихэр өвс нийт 6 зүйл ховор ургамал сонгон 2400 га-д тарималжуулсан байна.

Дүгнэлт: “Бунд-Овоо” ХХК, “Хонгор-Арал” ХХК-уудын ховор ургамал амжилттай тарьж ургуулсан туршлага дээр үндэслэн мэргэжлийн байгууллагын эрх авсан бүх ААН-үүдүүн үйл ажиллагаанд дүгнэлт хийж мэргэжлийн эрхийг сунгах эсэхийг шийдвэрлэдэг байх.

Гадаад зах зээлд эрэлттэй үндсийг нь ашигладаг ургамлыг байгалиас нь түүж бэлтгэх бодлогод өөрчлөлт оруулж, зөвхөн тарималжуулсан бол гадаадад гаргах бодлогоор зохицуулж, төрөөс урамшуулж татварын хөнгөлөлттэй нөхцөл байдал үзүүлэх шаардлагатай байна.

3.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох журмыг хуулиар тогтооно.

Хэрэгжилт: “Ургамал хамгааллын тухай” хуулийн 14 дүгээр зүйл Ургамлын хорио цээр тогтоох гэж зохицуулсан.

Дүгнэлт: “Ургамал хамгааллын тухай” хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино гэж заасан байгаа нь нийт ургамлын санг хамарч чадахгүй нөхцөл байдалтай байна.

4.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид *төрийн захиргааны төв байгууллага* гэх/-ын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно.

Хэрэгжилт: “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 6.1.3. ашиглаж болох пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдвартгүйтгэлийн бодисын жагсаалт, тэдгээрийн ашиглалтын хэмжээг хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр шинэчлэн батлах гэж заасны дагуу зохицуулж байна.

Дүгнэлт: Хэрэгжилт хангалттай.

5. Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамал хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхийг хориглоно.

Хэрэгжилт: Нэн ховор ургамал бүхий газрын судалгаа хийгдэж байсан боловч, түүнийг хамгаалах, нөхөн сэргээх зориулалтаар эзэмшүүлсэн газрын талбайн мэдээлэл улсын хэмжээнд байхгүй.

6.Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглоно.

Хэрэгжилт: Улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөверлөгдөн ирж, нутагшиж байгаа харь ургамлын нэрсийн жагсаалт байхгүй. Сүүлийн 5 жмлийн байдлаар БОАЖЯамнаас харь ургамал тарималжуулах зөвшөөрөл авсан ААН байхгүй боловч Дорнод аймгийн Халхгол суманд Селмарин гэх ургамлын үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр тарьж БНХАУ руу гаргаж байна.

Дүгнэлт: Харь ургамлын хаана ямар хэмжээгээр, ямар зориулалтаар тарьж байгаа тухай нэгдсэн судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг Үйлдвэр хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран бодлогын баримт бичигт оруулах

7¹ дүгээр зүйл. Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

Хэрэгжилт: Төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран 2012, 2016 онуудад ургамлын тархац нөөцийн судалгааг зарим аймгийн нуттуудаар хийлгэсэн байна.

Дүгнэлт: Зөвхөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын тархац нөөцийн судалгааг Байгалийн ургамлын тухай хуулийн 15.1-д үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргзэх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулах үүрэгтэй тул энэ заалтыг өөрчилж, бодлогын баримт бичигт боловсруулах хэмжээний судалгааг шинжлэх ухааны төв байгууллагатай хамтран явуулах гэж өөрчлөх.

2. Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Хэрэгжилт: Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг 2008 онд БОАЖСайдын А/194 тоот тушаалаар 105 зүйл ургамал, 2011 онд А/415 тоот тушаалаар 209 зүйл ургамал, 2015 онд А/282 тоот тушаалаар 595 зүйл ургамлын үнэлгээг тогтоосон байна.

Дүгнэлт: Хэрэгжилт хангалттай.

4. Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэж болох ургамлын төрөл, зүйлийн нэр, түүх дээд хязгаарыг төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.

Хэрэгжилт: Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэж болох ургамлын төрөл, зүйлийн нэр, түүх дээд хязгаарыг БОАЖСайдын 2014 оны А/258 тоот, 2015 оны А/268 тоот 2016 оны А/47, А/71 тоот, 2017 оны А/169 тоот тушаалуудаар баталсан.

Дүгнэлт: Хэрэгжилт хангалттай.

8 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газар

1.Байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий дараах газар нутагт ургамлыг нөөцийнх нь хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно:

1/хот, тосгон, бусад суурины ногоон бүс;

2/гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторхи газар;

3/нэн ховор амьтны байршил газар;

4/баянбурд;

5/ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар;

6/элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар;

7/хөрсний элэгдлээс хамгаалах зурvas газар.

2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6, 7-д заасан газар, түүний заагийг мэргэжлийн байгууллагаын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

Хэрэгжилт: 8.1.1/-7/-д заасан газарт ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж боломжгүй гэдэг дүгнэлт гаргасан мэргэжлийн байгууллага байхгүй. Сум дүүргийн ИТХ-аас гаргасан шийдвэр талаар БОАЖЯамны мэдээллийн санд байхгүй.

Дүгнэлт: Цаашид энэ заалтыг хэрэжүүлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг дарга нэрт үүрэг болгож, газар зүйн мэдээллийн систем дээр хориглосон газрын бүртгэж, нэгдсэн мэдээллийн сан гаргах.

9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлсний дараа сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

Хэрэгжилт: Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ гэдэг заалт хэрэгждэггүй.

Дүгнэлт: Зохих журам гэдэг нь тодорхойгүй тул ямар нэртэй журамыг хаанаас баталж өгөхийг хуулинд оруулах шаардлагатай.

10 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зориулалт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно.

Хэрэгжилт: Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулатаар ашиглаж болно гэсэн заалт хэрэгждэггүй ховор ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэдэг.

11 дүгээр зүйл. Ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Хэрэгжилт: Нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагаас авдаггүй, энэ тухай хуулийн заалтыг шинжлэх ухааны байгууллага, их, дээд сургуулиуд хэрэгжүүлдэггүй.

2. Судалгаа, шинжилгээ, ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор бусдад борлуулахыг хориглоно.

Хэрэгжилт: Судалгаа, шинжилгээний зориулалтаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор борлуулсан тухай мэдээлэл бүртгэгдээгүй, харин ахуйн зориулалтаар түүж бэлтгэсэн ургамлын түүхий эдийг зарж борлуулдаг тохиолдол элбэг байна. Жишээ нь самар, мөөг, ганга, арц, гоёо, цээнийн үндэс гэх мэт.

12 дугаар зүйл. Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах

Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

Хэрэгжилт: Иргэд ахуйн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын зөвшөөрлийг сум дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авдаггүй энэ тухай хуулийн мэдлэг дутмаг байдаг.

13 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

2. Эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага ховор болон элбэг ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болно.

3. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга, ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Хэрэгжилт: Ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно гэдэг заалт хэрэгждэггүй. Дэрэвгэр жиргэруү ховор ургамлын үндсийг эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэггүй аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтэн БНХАУ руу гаргаж байна.

Дүгнэлт: Байгалийн ургамлын тухай хуулийн 10 дугаар зүйлд ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглаж болно гэж засантай ховор ургамлыг үйлдвэрлэлийн зориулатаар түүж бэлтгэж байгаа нь зөрчилдөж байна. Мөн ховор ургамлын зөвхөн эм үйлдвэрлэлд ашиглана гэдэг заалт хэрэгждэггүй тул үүнийг одоогийн нөхцөл байдалд тохируулан бодлогын баримт бичигт өөрчлөх хэрэгтэй.

4. Ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны 50 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тохиолдолд тухайн ургамлыг тарималжуулсан байна.

Хэрэгжилт: Ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны 50 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тухайн ургамлыг тарималжуулдаггүй, ургамал нөхөн сэргээсэн талбайгаа тухайн сум орон нутагтаа хүлээлгэж өгдөггүй.

Дүгнэлт: Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тухайн ургамлыг тарималжуулах, ургамал нөхөн сэргээсэн талбайгаа сум орон нутагтаа хүлээлгэж өгдөг байх эрх, үүрэг, хариуцлагатай байх журам боловсруулж, мөрдүүлэх.

14 дүгээр зүйл. Бэлчээр, хадлангийн ургамлыг мал тэжээх зориулалтаар ашиглах

1. Бэлчээрийн мал аж ахуйн эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа /оршин байгаа/ сум, дүүргийн газар нутагт мал бэлчээх, хадлан авах зэргээр бэлчээр, хадлангийн газар дахь ургамлыг ашиглахдаа Газрын тухай хуулийн 52, 53 дугаар зүйлийг баримтална.

/Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нэн ховор ургамлыг хамгаалах зорилгоор түүний ургадаг газар мал бэлчээх, хадлан авахыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн 2 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно.

/Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3. Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нехцэлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга шийдвэрлэнэ.

Хэрэгжилт: Бэлчээр, хадлангийн ургамлыг зөвхөн мал тэжээх зориулалтаар ашиглах хуулийн зохицуулалт байгаа боловч Гаалийн ерөнхий газрын мэдээгээр хадлангийн зориулалтаар бэлтгэсэн өвс нэрийн дор их хэмжээгээр бэлтгэж, улсад байгалийн нөөц ашигласны төлбөр огт төлөлгүй БНХАУ руу 2016-2017 онд 176.1 мянган тонн байгалийн ургамал гарсан байна.

Дүгнэлт: Бэлчээр, хадлангийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар хадаж гадаад улс руу гаргах эрх зүйн зохицуулалт хийж, үүнд тохирсон байгалийн нөөцийн төлбөр, тэмдэгтийн хураамжийн татварийн бодлого боловсруулах.

16 дугаар зүйл. Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацаа

1. Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх журам, ашиглахыг зөвшөөрсөн хэмжээ, хугацааг баримтлан түүж бэлтгэнэ.

2. Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацааг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Хэрэгжилт: БОАЖСайдын 2015 оны А/381 тоот тушаалаар “Байгалийн ургамал түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох журам” баталсан байна.

17 дугаар зүйл. Ургамлыг гадаад улсад гаргах, гадаадын иргэн түүж бэлтгэх

1. Ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Хэрэгжилт: Хадлангийн зориулалтаар бэлтгэсэн ургамлаас бусад ургамлыг БОАЖЯамнаас зөвшөөрөл олгож байна.

4. Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно.

Хэрэгжилт: Ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно гэсэн заалт хэрэгждэггүй. Байгалийн Дэрэвгэр жиргэруү ховор ургамлыг эцсийн бүтээгдэхүүн болголгүй БХНАУ руу 2015-2017 онд 361.9 тонн гарсан байна.

Дүгнэлт: Гадаад зах зээлд эрэлттэй үндсийг нь ашигладаг ховор ургамлыг байгалиас нь түүж бэлтгэх бодлогод өөрчлөлт оруулж, зөвхөн тарималжуулсан бол гадаадад гаргах бодлогоор зохицуулж, төрөөс урамшуулж татварын хөнгөлөлттэй нөхцөл байдал үзүүлэх шаардлагатай байна.

5. Судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах ургамлын хэмжээг Засгийн газар тогтооно.

Хэрэгжилт: Судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах ургамлын хэмжээг тогтоосон засгийн газрын тогтоол байхгүй.

Дүгнэлт: Судалгаагаар гарах ургамлын төрөл, зүйлийн хэмжээг Засгийн газрын тогтоолоор батлуулах боломжгүй тул үүнийг асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага журмаар зохицуулах хэрэгтэй.

20 дугаар зүйл. Мансууруулах бодис бүхий ургамал

1. Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

Хэрэгжилт: Монгол улсын байгаль орчны сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 1995 оны 139/A/148 тоот тушаалаар 1. Мансуурлагч намуу-Papaver somni ferum, 2. Таримал олс-Cannabis sativa, 3. Хогийн олс- Cannabis ruderalis гэсэн 3 зүйл ургамлыг баталсан.

2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгож тэдгээрийг тусгай бүртгэлд бүртгэнэ.

/Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

Хэрэгжилт: Мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгжийн судалгааг Эрүүл мэнд, спортын яамнаас судалгааг авах

3.Иргэн, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно.

Хэрэгжилт: Мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарьж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийн сан БОАЖЯаманд байхгүй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үнэлэх үе шатны төгсгөлд томьёолсон шалгуур үзүүлэлтэнд тулгуурлан дараах байдлаар дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулав. Үүнд:

- Үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах,
- Үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох зөвлөмж гаргах.

4.1. Үнэлэлт, дүгнэлт

БүтХ-ийн 1 дүгээр зүйл, 2¹ дүгээр зүйл, 3 дугаар зүйл, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйл, 7¹ дүгээр зүйл, 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйл, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйл, 20 дугаар зүйлүүдийн хэрэгжилтийн үр дагаварт "Зорилгод хүрсэн түвшин", "Практикт хэрэгжсэн байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээний үр дунг заалт бүрээр дүгнэн өмнөх бүлэгт үзүүлсэн тул нийтлэг шинж болон тусгайлсан дараах байдалтай байв.

- Нэр томьёог шинэчлэн баталж хэвшүүлэх,
- Бусад хуулийн хэм хэмжээтэй зөрчилдөж буй заалтуудыг уг хуулиас хасах,
- Төлбөр хураамжийг тусгайлсан хуулийн хэм хэмжээнд тохируулан түүнд нийцүүлэх,
- Шинэ ойлголт, түүнийг хэрэгжүүлэх аргачлалыг нэвтрүүлэх зорилгоор тусгайлсан бодлогын баримт бичиг боловсруулах,
- Уг хуулийн үйлчлэлийн дагуу холбогдох эрх бүхий этгээдүүдийн эрх, үүргийг шинэчлэн тогтоож бусад хуультай нийцүүлэх,

4.2. Зөвлөмж

Үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах санал, зөвлөмж гаргаж байна.

БүтХ-ийн холбогдох бүлэг, зүйл, заалтад хийсэн дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн, багийн зүгээс БүтХ-ийг шинэчлэн найруулах санал гаргаж байна. Түүнчлэн уг хуулийг шинэчлэн найруулахдаа дараах зохицуулалтуудыг тусгахыг мөн санал болгож байна. Үүнд:

- Байгалийн ургамалыг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалт хийх боломжийг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн зүйлчлэх,
- Байгалийн ургамалыг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй байлгах үүднээс аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Мэргэжлийн хяналтын газар, хэлтэстэй хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх,
- Уг хуулийг дагаж гарах хуучирсан дүрэм, журмыг төсөл боловсруулах явцад зэрэгцүүлэн хийх,
- Уг хуультай холбогдуулан гарах нөөц тогтоох, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг БОАЖЯ-наас тусгайлан ажлын хэсэг гаргаж шинэчлэн батлах, шинээр бүрдүүлэх,
- Шинэ төрлийн үүсэх зохицуулалт, түүнд тохирсон нөөцийн төлбөр, хураамжийн татварын бодлого боловсруулах, холбогдох хуультай нийцүүлэх,

ОНЧ ШИЙДЭЛ ТББ

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоо

Онч Шийдэл ТББ
2018

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх-/ын дагуу тооцлоо.

Уг аргачлалд заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог бөгөөд Уул уурхайн нөхөн сэргээлтийн тухай хуулийн төслөөр нийтлэг байдлаараа иргэн, хуулийн этгээд, төрд шинэ чиг үүрэг нэмэх, шинээр үүрэг хүлээлгэх зохицуулалтуудыг тусгасан байна.

Хуулийн төслөөр Аймаг, Нийслэлийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Төрийн өмчит шинжлэн ухааны байгууллага, байгалийн ургамлыг тодорхой зориулалтаар ашиглах эрх бүхий хуулийн этгээд зэрэгт үүрэг шинээр нэмж байгаа төрд үүсэх зардлын тооцоог субъект тус бүрээр тооцохыг зорилоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг.Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох; /хүний нөөцийн хэрэгцээ тогтоогдсон тохиолдолд/

4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох; /хүний нөөцийн хэрэгцээ тогтоогдсон тохиолдолд/
5. Хувилбарыг нягтлах. /хүний нөөцийн хэрэгцээ тогтоогдсон тохиолдолд/

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон.

Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй.

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200¹ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/
1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу $200 \times 8 / 1600$ ажлын цаг буюу $1,600 \times 60 / 96000$ минут ажиллана гэсэн үг.

Аймаг, нийслэлийн, сум, дүүргийн Засаг дарга:

Хуулийн төслөөс:

7.1. Байгалийн ургамлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийг байгаль орчны чиглэлээр төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга тухай шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 5 жилийн хугацаатай батлуулж нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг нь зохион байгуулна.

7.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга Байгалийн ургамлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

7.5. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны серөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны

¹Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ².

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь дээрх зүйлд тусгагдсан үйл ажиллагааг зохион байгуулах давтамж тогтмол биш эсхүл жилдээ 1 гүйцэтгэх тул аргачлалын дагуу тохиолдлын давтамжийг үйл ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Тоон үзүүлэлт /мин
Байгалийн ургамлыг хамгаалахаад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулах төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга тухай шатны иргэдийн төлөөлөгчдд	Байгалийн ургамлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулах	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,2 ³	480
		танилцах, мэдээллээ үнэлэх	3 өдөр /24 цаг/ 1440 мин	0,2	240
		нягтлах	2 өдөр /8цаг/ 480 мин	0,2	96
		хянах	2 өдөр /8цаг/ 480 мин	0,2	96
	тухай шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах	Хөтөлбөрийг танилцуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,2	480
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	0,2	240
		Батлах, албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	0,2	48
		Мэдээлэл хүргүүлэх	2 өдөр /16цаг/ 960 мин	0,2	192

² Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.14 дэх заалтад “гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах” гэж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтад “байгалийн баялгийг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, түймэр зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх;” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэж заасан тул хүний нөөцийн хэрэгцээ болон тесев тооцох шаардлагагүй болно.

³ Тус үйл ажиллагааг 5 жил тутамд хэрэгжүүлэх тул тохиолдлын тоог 0,2 гэж тооцлоо.

ийн хурлаар 5 жилийн хугацаатай батлуулж нутаг дэвсгэртээ хэрэгжилти йг нь зохион байгуулна.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Хэрэгжилтийн талаарх мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
Аймаг, нийслэлийн Засаг дарга Байгалийн ургамлыг хамгаалаха д чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрий н тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25- ны дотор төрийн захиргааны төв байгууллага д ирүүлнэ.	Арга хэмжээний тайлан хүргүүлэх	Хэрэгжилтийн талаарх мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		Хэрэгжилтийн талаарх боловсруулса н мэдээллийн нягтлах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		Тайланг хүргүүлэх	2 өдөр /8цаг/ 480 мин	1	960
					17712

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
------	---------------------------	--------------------	------------------------------------

		ажлын цаг/мин	
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын тамгын газар	17712 мин	96000	0,18

Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Засаг даргын газар нь нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг зохистой ашиглах, ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхэд 11712 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,18 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа. Өөрөөр хэлбэл уг ажлыг хариуцсан орон тоо гаргах шаардлагагүй бөгөөд одоо ажиллаж байгаа албан хаагчаар хариуцан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам:

Хуулийн төслийн:

8.1. Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

8.2. Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ болон экологи эдийн засгийн үнэлгээ батлах аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг төрийн өмчтэй шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.

13.5. Байгалийн ургамлыг тарималжуулах, гадаад улсад гаргахтай холбоотой журмыг байгаль орчин хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас батална.

16.6. Энэ хуулийн 16.5 дахь хэсэгт заасан эрхийн бичгийн загварыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.5. Байгалийн ургамал түүж бэлтгэх, гадаад улсад гаргах, оруулахтай холбоотой журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хуулийн төсөлд тусгагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуул хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин
Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.	Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааны ажлыг хийх	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,5 ⁴	1200
		танилцах, мэдээллээ үнэлэх	3 өдөр /24 цаг/ 1440 мин	0,5	720
		Нягтлах	1 өдөр /8цаг/ 480 мин	0,5	240
		Боловсруулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,5	1200
		Нягталж, албажуулах	1 өдөр /8цаг/ 480 мин	0,5	240
Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ болон экологи эдийн засгийн үнэлгээ батлах аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ болон экологи эдийн засгийн үнэлгээ батлах	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	9600
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	9600
		Нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	5760
		Боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	5760
		Нэгтгэн дүгнэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	3840
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	960

⁴ Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жилд нэг удаа хийх тул давтамжийн тоог 0,5 гэж тооцлоо.

Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.	Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа тогтоох	мэдээлэл цуглуулах	10 өдөр /40цаг/ 4800 мин	1	4800
		танилцах, мэдээллээ үнэлэх	10 өдөр /40цаг/ 4800 мин	1	4800
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Албажуулж, батлуулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
Энэ хуулийн 16.5 дахь хэсэгт заасан эрхийн бичгийн загварыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Ургамлыг ашиглах эрхийн бичгийн загварыг батлах	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		нэгтгэн дүгнэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
Байгалийн ургамал түүж бэлтгэх,	Байгалийн ургамал түүж бэлтгэх,	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400

гадаад улсад гаргах, оруулахтай холбоотой журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	гадаад улсад гаргах, оруулахтай холбоотой журмыг батлуулах	танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулax	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		нэгтгэн дүгнэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
					66420

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Байгаль орчин, яалал жуулчлалын яам	66420 мин	96000	0,7

Байгаль орчин, яалал жуулчлалын яам нь улсын хэмжээнд ашиглалтад өртөмхий ургамалын тархац, нөөцийн судалгаа гаргах, ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал батлах, үйлдвэрийн зориулалтаар бэлтгэх ургамлын зүйлийн нэр, хэмжээ хугацаа, тарималжуулах, гадаад гаргах журмыг батлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхэд 66420 мин цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,7 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа. Өөрөөр хэлбэл уг ажлыг хариуцсан орон тоо гаргах шаардлагагүй бөгөөд одоо ажиллаж байгаа албан хаагчаар хариуцан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Төрийн өмчит шинжлэх ухааны байгууллага

Хуулийн төслөөс:

7.8.Нэн ховор, ховор, унаган, завсрын унаган болон үлдвэр ургамлын удмын санг хадгалан хамгаалах зорилгоор тарьж ургуулсан ургамлын цуглуулгыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын дэргэд хадгална.

8.1.Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

8.4.Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.

Хуулийн төсөлд тусгагдсан Төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин
Нэн ховор, ховор, унаган, завсрын унаган болон үлдвэр ургамлын удмын санг хадгалан хамгаалах зорилгоор тарьж ургуулсан ургамлын цуглуулгыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын дэргэд хадгална.	Ургамлмын цуглуулгыг хадгалах	Ургамлыг цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	12 ⁵	28800
		хадгалах	3 өдөр /24 цаг/ 1440 мин	12	17280
		Бүртгэл хөтлөх	1 өдөр /8цаг/ 480 мин	12	5760
		Хяналт тавих	3 өдөр /24 цаг/ 1440 мин	12	18800

⁵ Ургамлмын цуглуулгыг хадгалах давтамжийн тоог тодорхой тооцооплох боломжгүй тул 12 гэж тооцлоо.

Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.	Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааны ажлыг хийхь саналаа танилцуулах	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,5 ⁶	1200
		танилцах, мэдээллээ үнэлэх	3 өдөр /24 цаг/ 1440 мин	0,5	720
		нягтлах	1 өдөр /8цаг/ 480 мин	0,5	240
		Боловсруулax	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,5	1200
		Нягталж, албажуулах	1 өдөр /8цаг/ 480 мин	0,5	240
		Саналаа БОАЖЯ-нд хүргүүлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	0,5	240
Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг төрийн өмчит шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.	Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа тогтоох, санал гаргах	мэдээлэл цуглуулах	10 өдөр /40цаг/ 4800 мин	1	4800
		танилцах, мэдээллээ үнэлэх	10 өдөр /40цаг/ 4800 мин	1	9600
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулax	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Албажуулж, батлуулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Саналаа БОАЖЯ-нд хүргүүлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
					93200

⁶ Ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жилд нэг удаа хийх тул давтамжийн тоог 0,5 гэж тооцлоо.

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Байгаль орчин, яалал жуулчлалын яам	96320 мин	96000	0,9

Төрийн өмчит шинжлэн ухааны байгууллага нь нэн ховор, ховор, унаган, завсрыйн унаган болон үлдвэр ургамлын удмын санг хадгалан хамгаалах зорилгоор тарьж ургуулсан ургамлын цуглуулгыг хадгалах, улсын хэмжээнд ашиглалтад өртөмхий ургамалын тархац, нөөцийн судалгаа ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал батлах, үйлдвэрийн зориулалтаар бэлтгэх ургамлын зүйлийн нэр, хэмжээ хугацаа, зэргийг тогтооход БОАЖЯ-нд саналаа танилцуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхэд 93200 мин цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,9 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа. Өөрөөр хэлбэл уг ажлыг хариуцсан орон тоо гаргах шаардлагагүй бөгөөд одоо ажиллаж байгаа албан хаагчаар хариуцан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Хуулийн этгээдэд үүсэх зардал

Хуулийн төслийн:

7.5.Ургамлыг гол түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

9.1.Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд зөвшөөрлийн дагуу өөрийн хөрөнгөөр биологийн нөхөн сэргээлт хийж тухайн шатны Засаг даргад хүлээлгэн өгнө.

19.1.4.ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төслийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ” гэж, мөн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд зөвшөөрлийн дагуу өөрийн хөрөнгөөр биологийн нөхөн сэргээлт хийж тухайн шатны Засаг даргад хүлээлгэн өгнө.” гэж заасан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалтад “ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээд өөрийн эзэмжиж байгаа газрыг аливаа сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үүргийг хүлээдэг тул шинэ үүрэг гэж үзэхгүй болно.

Түүнчлэн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 19.14 дэх заалтад “Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд зөвшөөрлийн дагуу өөрийн хөрөнгөөр биологийн нөхөн сэргээлт хийж тухайн шатны Засаг даргад хүлээлгэн өгнө” гэж заасныг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд нарийвчлан заасан байна. Иймд шинэ үүрэг гэж үзэхгүй тул хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохгүй болно.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд тэмдэгтийн хураамжийн дээд хягзаарыг нэмсэн тул хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардал тодорхой нэмжээгээр нэмэгдэнэ. Энэ хэсэгт шинээр хуулийн этгээдийн хүний нөөцийн зардал үүсэхгүй болно.

Дүгнэлт:

Хуулийн төслөөр Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны зардал, хүний нөөцийн хэрэгцээ шаардлагааг тооцлоо.

Тооцооллоос үзэхэд Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын хүний нөөцийн нэмэлт хэрэгцээ шаардлага үүсэхгүй гэсэн тооцол гарсан.

Хүний нөөцийн хэрэгцээ шаардлага үүсээгүй тул хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох болон хувилбарыг нягтлах шаардлагагүй байна.

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нээлттэй санал авахаар БОАЖЯ-ны вэб сайтад 2018.10.10-ны өдөр байршуулсан.

① https://www.mne.mn/Prage/_id=452

The screenshot shows the official website of the Mongolian Ministry of Environment (MNE) at https://www.mne.mn/Prage/_id=452. The header includes the MNE logo and navigation links for 'Bogd Ulaan, Govisayhan', 'Хүчин чийг сонирхжүүцэвэл ишдүүгээ болсан хамгийн олонхи мэдүүлэг', 'Түүхэндээс засагтаж зардлыг', 'Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам', 'Бидний тухай', 'Шилжигдэвшиг', 'Хууль, эрх зүй', 'Мэдээ, мэдээлэл', 'Ил тод байдал', and 'Гадаад хариулцаа'. The main content area features a dark banner with the text 'ЭРХ ЗҮЙН АКТ ТӨСӨЛ'. Below it, a table lists various sections: 'ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ' (with '2018.04' date), 'Салбарын хууль' (with '2018.04' date), 'Ерөнхийлөгчийн зарлиг' (with '2018.04' date), 'Улсын Их Хурлын тогтоол' (with '2018.04' date), 'Засгийн газрын тогтоол' (with '2018.04' date), 'Сейдийн туштал' (with '2018.04' date), and 'Үндэсний зөвлөвөр' (with '2018.04' date). A detailed list of changes is provided under the 'ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ' section:

- Бий болсон газарчилж тухайн эзлэхийн наийруулж аж санал авч болна.
- Нийкээр чийн баг, түүнийч хийдээс давхардал зүүрхийг цэвэрэхгүй хүчийн төсвэд таатайлан бийнэ.
- "Түүхэндээс засагтаж зардлыг" БОАЖС-ын гүйцэтгэлийн төмөр замаар шийдвэрлэх болно.
- Газарчилж чийн тогтолцоогоо чөлөөлж, импортоогоо зөвлөхийн тогтолцоогоо зорилтуулж болно.
- Засгийн тогтолцоогоо зөвлөхийн тогтолцоогоо зорилтуулж болно.

ХУУЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЧОО

№	Санал өгсөн иргэний нэр	Өгсөн санал	Саналыг тусгасан байдал
2019.09.28-ны өдрийн хэлэлцүүлэг			
1.	И.Түвшигтогтох -ШУА-ийн БЦХ-ийн захирал Ph.D	<p>1. Байгалийн ургамал- Байгаль дээр өөрийн түүхэн хөгжлийн зүй тогтлын дагуу ургаж байгаа ургамал.</p> <p>2. Байгалийн ургамлын түүхий эд - Үйлдвэрлэл, аж ахуй, ахуйн хэрэгцээнд зориулан авч хэрэглэх тодорхой зүйл ургамлын газрын газрын дээрх болон доорх хэсэг юмуу тодорхой эд эрхтэн (үндэс, үндэслэг иш, булцуу, иш, найлзуур, нахиа, навч, цэцэг, жимс, үр) эсвэл аль нэг эрхтний (цэцгийн дэлбэ, цоморлиг, үрийн идээ, ишний гол гэх мэт.) эсвэл ургамлын анхдагч болон хоёрдогч (шүүс, давирхай, бал г.м.) бүтээгдэхүүн.</p> <p>3. Биологийн нөөц (БН) – Тодорхой зүйл ургамлын тархсан бүх нутаг дэвсгэр дэх бүх бодьгалын түүхий эдийн нийт хэмжээ (г, кг, т).</p> <p>4. Ашиглалтын нөөц - Бэлтгэл явуулах тохиромжтой газрын таваарын бодьгалын түүхий эдийн хэмжээ (г, кг, тн).</p> <p>5. Жил бүрийн бэлтгэлийн хэмжээ - тухайн талбайгаас жил бүр бэлтгэх түүхий эдийн боломжит хэмжээ. Бэлтгэлийн талбай дахь түүхий эдийн бэлтгэлийн нөөцийн хэмжээг бэлтгэлийн эргэлтэд хувааж тодорхойлдог.</p> <p>Энэ нэр томьёо яамнаас жил бүр зүйл ургамал, түүний жил бүрийн бэлтгэлийн хэмжээг тогтооно гэж оруулах</p>	<p>1. Саналыг хүлээн авав</p> <p>2.Хэт дэлгэрэнгүй тайлбартай учраас тодорхойлолтыг товчлон оруулав</p> <p>3. Саналыг хүлээн авав</p> <p>4. Саналыг хүлээн авав</p> <p>5. Саналыг тусгах боломжгүй.</p>

2.	О.Энхтуяа-ШУА-ийн БЦХ-ийн эрдэмтэн нарийн Ph.D	<p>Ургамал хамгаалах гэсэн хэсэгт 2 зүйл оруулах саналтай байна.</p> <p>1. Байгалийн ургамал, түүний нөөцийг бүртгэх, тоолох, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх шинжлэх ухааны суурь мэдлэгийг үндэслэн тогтоох, дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар үр дүнг бодлого, хөтөлбөрт тусгах, нөлөөлөх үйл ажиллагааг ургамал судлалын хүрээлэн (ботаникийн хүрээлэн), гадаад болон дотоодын судалгаа шинжилгээний төрийн бус мэргэжшсэн /итгэмжлэгдсэн/ байгууллага явуулах бүрэн эрхтэй</p> <p>2. Байгалийн ургамлыг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үр ашгийг тэгш хуваарилах талаархи хууль, тогтоомж, тэдгээрийг дагаж мөрдөхтэй холбогдсон шийдвэр, технологийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих бүрэн эрхийг нутгийн захиргааны байгууллага эдлэнэ.</p>	<p>1. Саналыг өөрчлөн найруулж тусгав</p> <p>2. Саналыг өөрчлөн найруулж тусгав</p>
3.	Г.Очирбат- Биологийн шинжлэх ухааны доктор	<p>1. Ботаникийн хүрээлэнгээ салгах асуудлыг ярилцаж, хуулийн төсөлд оруулж болдоггүй юм уу, Хүрээлэн салгах асуудалд нэг ч хүн саналаа өгөхгүй юм.</p> <p>2. Манай улс байгалиас үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын нөөц байхгүй шүү. Иймд үйлдвэрлэлийн зориулалтаар гэдэг дээрээ анхаараарай.</p>	<p>1. Энэ асуудлыг энэхүү хуулиар зохицуулах боломжгүй тул саналыг хүлээн авах боломжгүй</p> <p>2. Саналыг хүлээн авав</p>
4.	Н.Очгэрэл-ШУА-ийн БЦХ-ийн генобанк, интродукцийн лаб-ийн эрхлэгч Ph.D	<p>Хуулийн төсөлд ботаникийн цэцэрлэгийн асуудлыг оруулж болох уу. Ямар нэг байдлаар хуульчилж өгөхгүй бол цэцэрлэгийн газрыг янз бүрийн байдлаар аваад дуусгах нээ. Бид нэн ховор, ховор ургамлын генфондыг амьд хэлбэрээр хадгалж үлдэхгүй бол</p>	<p>Саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгав</p>

		сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйл гээд хэдэн зүйл ургамал устаж алга болж байгааг бид өнөөдөр мэдэхгүй байна. Иймд энэ асуудлыг зайлшгүй хуульд оруулж өгмөөр байна.	
5.	М.Ургамал- ШУА-ийн БЦХ-ийн ангилал зүйн лаб-ийн эрхлэгч Ph.D	Нэн ховор, ховор, элбэг ургамлын статусыг улаан дасны үнэлгээтэй уялдуулмаар байна. Нэн ховор ургамлыг тодорхойлолт дээр “устаж байгаа болон устаж болзошгүй” гэж , ховор ургамал дээр “эмзэг” гэж тус тус нэмж оруулах хэрэгтэй байна.	Саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгав
6.	2019.11.30-ны өдрийн хэлэлцүүлэг		
7.	Ц.Банзрагч-Байгаль орчны гавьяат ажилтан Ph.D	<p>1. Нэн ховор ургамлыг <i>in-situ</i>, ховор, элбэг ургамлыг <i>ex-situ</i> орчинд хамгаална гэж оруулах, гербар гэж орсон байна, энд Монгол нэр томъёо олж оруулах хэрэгтэй.</p> <p>2. Ойн дагалт баялагийн хувьд самрын шавхdasыг зөвшөөрөлд хамруулж болохгүй. Дагалтын зөвшөөрлийг яамнаас олгодогийг болих, төлбөрийн асуудал дээр улсын тэмдэгтийн хураамж 3000 төгрөг, байгалийн нөөц ашигласны төлбөр 800 төгрөг байгаа нь зохимжгүй байгаа.</p> <p>3. Байгалийн ургамлын хамтын нөхөрлөлийн асуудлыг сайн оруулж өгөөрэй.</p> <p>4. 2.1. дэх хэсэгт “Ойн хууль”-ийг нэмж оруулах. Ингэснээр байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, зохицтой ашиглах асуудлыг байгалийн ургамлын тухай хуулиар зохицуулах нөхцөл бүрдэж энэ хууль гол хууль нь гэсэн нь харагдах болно.</p>	<p>1. Саналдыг хүлээн авав</p> <p>2. Энэ хуулиар зөвхөн 1 зүйл ургамлыг тусгайлан заалт болгон оруулах боломжгүй тул, журмаар нарийн зохицуулахаар оруулав.</p> <p>3. Саналыг хүлээн авав</p> <p>4. Саналыг тусгав</p> <p>5. Ургацыг хэмжээг тогтоохыг хуульд оруулах боломжгүй тул саналыг хүлээн авах боломжгүй</p>

		5. Тархац нөөцийн судалгааг 5 жил гэж оруулсан байна. Ургацын хэмжээг жил бүр тогтоож явах ёстой.	
8.	Батмөнх-Самар үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн, Грийн пинус ХХК-ийн захирал	Самрын үнэдсний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих асуудлаа оруулаач ээ. Орон нутгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 500, 800 төгрөгийг нэг талд нь шийдвэрлэх шаардлагатай байна. Самрыг тусад нь хууль эрх зүйн орчноор зохицуулах. Ашиглалтын нөөцийг 20% гэж тавьсан нь болох уу “ashiглалтын нөөц” гэсэн тодорхойлолтыг илүү тодорхой болгож өгөөч.	Саналыг хүлээн авлаа, энэ асуудлыг журмаар нарийн зохицуулж оруулна. 500, 800 төгрөгийн хувьд БОНХС-ийн тушаалаар зохицуулагдаж байгаа тул энэ хуулиар зохицуулах боломжгүй.
9.	Хашмаргад- Горхи тэрээлжийн БЦГ-ын дарга	1.Хадлан бэлтгэх зөвшөрлийг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, 2.TХГ-ын саналыг үндэслэн гэж оруулах. Хадлан гэсэн хэсэгт ТХГ-аа оруулж өгмөөр байна.	1.Саналыг хүлээн авав 2.Энэ нэн хуулиар зохицуулах боломжгүй
10.	Цэндээхүү-Биологийн шинжлэх ухааны доктор	Харь зүйл ургамал гэсэн тодорхойлолтыг зөв болгох. Мансууруулах бодис бүхий ургамлыг тарималжуулж болохгүй.	Саналыг хүлээн авав Мансууруулах бодис бүхий ургамлыг тарималжуулах гэж оруулаагүй
11.	Энхсайхан- ОСХТ-ийн зөвлөх	Ашиглалтын горимд хатуурхсан заалтууд байна. Нэн ховор, ховор ургамлыг ахуйн зориулалтаар түүлгэх хэрэгтэй. Хуш модыг ховор ургамалд оруулахгүй шүү. Модлог ургамалд ашиглахгүй зүйл гэж байхгүй, ойн тухай хуультай уялдуулаарай. Байгалийн ургамлын хадлангийн зориулалтаар бэлтгэн гадаад улсад гаргахыг хориглоно гэсэн байна төлбөрөө төлөөд гаргаж болох уу	Хуш модыг ховор ургамалд оруулах эсэхийг олон улсын улаан дансны үнэлгээгээр үнэлж ямар статуст орохыг тодорхойлно. Хуулийн төсөлд оруулах боломжгүй
12.	Отгонбилэг-Монго эм ХХК-ийн ажилтан Ph.D	1.“Акт” гэсэн гадаад үгийг хасаж “Эрх зүйн баримтуудаас” гэж оруулах хэрэгтэй. “Тарималжуулсан байгалийн ургамал гэснийг “Нутагшуулсан байгалийн ургамал” болгон,	1.Саналуудыг хүлээн авав

		<p>"Хатаамал гэсэн үгийн "Хатаадас" болгон, "Байгалийн ургамлын ангилал" гэснийг "Байгалийн ургамлын ашиглалтын ангилал" болгон, "Байгалийн ургамлын олон янз байдал" гэснийг "ур, биет ургамал хатаадас" болгон, "Харь зүйл ургамлыг байгальд тарьж ургуулахыг хориглоно" гэснийг "Түргэн тархаж байгалийн унаган төрхийг алдагдуулах харь ургамлыг тарьж ургуулахыг хориглоно" гэж тус тус өөрчлөн оруулах саналтай байна.</p> <p>2.Ховор ургамлын жагсаалт шинэчлэхдээ их анхаарах хэрэгтэй байна. Одоо элбэг ургамлын жагсаалтад байгаа ховор ургамалд орох шаардлагатай сибирь тэс, ганц навчит дэгд, бор цоохор цахилдаг, ганга, өргөн навчит хөвөнт гэх мэт тархалт нөөц, ашиглалт зэрэг олон талаас нь бодууштай ургамал олон байгааг анхаараарай.</p> <p>3.Монгол хэлний тархлааг бодолцон зарим үгийг Монгол үгээр бичвэл зүгээр юм шиг санагдаж байна.</p>	
13.	Цогтбаатар-Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга	<p>1.Хуулийн зорилт хэсгээс "Ой" гэсэн үгийг хасаж байгааг дэмжиж байна.</p> <p>2.Тарималжуулсан байгалийн ургамлын экспортын зөвшөөрлийг хаана ямар байгууллагаас олгох, яаж зохицуулж байх талаар тодорхой оруулах.</p> <p>2.Ургамал түүж бэлтгэсэн газраа нөхөн сэргээлт хийлгүй орхидог, иймд нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд дахин ургамал түүж бэлтгэхгүй гэсэн заалт оруулмаар байна.</p>	Саналуудыг хүлээн авч хуулийн төсөлд тусгав

14.	Л.Энхбат-Астра рүүт ХХК-ийн захирал	Тарималжуулсан ховор ургамлыг гадаад улсад гаргахад кг тутам 1000 төгрөгийн хураамж авдаг. Үүнийг болиулж болох уу, байгалийн ургамал тарималжуулах нь хөрөнгө мөнгө их шаарддаг, улсаас ямар нэг дэмжлэг туслалцаа байдаггүй. ААН-үүдээ дэмжих болдоггүй юмуу.	Энэ асуудал Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулагддаг. Саналыг тусгах боломж байгаа эсэхийг судалж үзье.
15.	С.Намнансүрэн-Хонгор арал трейд ХХК-ийн захирал	Байгалийн ургамлыг тарималжуулах асуудлыг нарийн хуульчлах нь зүйтэй байна. Одоо байгаа хууль эрх зүйн орчин их бүрхэг. Тарималжуулсан ургамалд татвар авахыг болиулах тал дээр санал нэг байна.	Саналыг хүлээн авлаа
16.	2019.12.07-НЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ		
17.	Ш.Дариймаа-МУБИС-ийн багш Биологийн ухааны доктор	Хуулийн төсөлтэй танилцлаа, ургамлын статусыг шинжлэн батлахдаа олон жил судпалгаа хийсэн ахмад судлаачдын саналыг сайн асуугаарай.	Саналыг хүлээн авлаа
18.	Оюунцэцэг-МУИС-ийн БУС-ийн биологийн тэнхимийн эрхлэгч Ph.D	Ургамлын түүхий эд гэснийг нэг бүрчлэн зааж оруулахад төвөгтэй тийм учраас газрын дээд болон доод хэсэг гэж оруулах нь зүйтэй.	Саналыг хүлээн авлаа
19.	Пунсалпаамуу- МУБИС-ийн багш Ph.D	Доод ургамалаа энэ хуульд хамруулж байгаа юу. Энэ маш чухал шүү.	Саналыг хүлээн авлаа, нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг дээд, доод ургамал гэсэн 2 хавсралттайгаар батлахаар ажиллаж байгаа.
20.	Ж. Аззаяа-ШУА-ийн БЦХ-ийн ажилтан Ph.D	Ашиглалтын нөөцөө бид их зөв гаргах зүйтэй шүү. Энэ нь экосистемдээ маш чухал.	Саналыг хүлээн авлаа.

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Т.Булган	Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
П.Цогтсайхан	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга
Г.Оюунгэрэл	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн
О.Батсайхан	Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
И.Түвшинтогтох	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал доктор (Ph.D), дэд профессор /тохиролцсоноор/